

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН 2015 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАМГААЛАХ, ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО,
ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1 Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.3-т заасны дагуу Комисс нь бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар илтгэл бичиж жил бүрийн эхний улиралд багтаан Улсын Их Хуралд илтгэдэг. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх ХЭҮК-ын 14 дэх илтгэлийг боловсруулж 2015.03.31-нд УИХ-ын дарга З.Энхболд-д өргөн барив. 14 дэх илтгэлийг иргэний нийгмийн байгууллагынханд танилцуулах уулзалтыг 2015.04.14-нд зохион байгуулж, уулзалтад нийт 57 ИНБ-ын төлөөлөл оролцсон бөгөөд УИХ-ын Хүний эрхийн дэд хорооны дарга Ё.Отгонбаяр, Комиссын дарга, гишүүд үг хэлж оролцогчдын асуулт хариултанд хариулж санал солилцов.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэлийг Комиссын цахим хуудас болон фэйсбүүк хуудаст байршуулж, “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн 2015 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн дугаарт нийтлүүлж мөн монгол хэл дээр 2500 хувь, англи хэл дээр 200 хувь тус тус хэвлүүлж, төр, төрийн бус, олон улсын байгууллагуудад хүргүүлж олон нийт танилцах боломжийг бүрдүүлж ажиллав.

1.2 Хяналт шалгалт

Хүний эрх зөрчигдөж буй шалтгаан нөхцөл, эрсдэлийг судлан сонгон авсан объектод хяналт шалгалт хийх ажлын хүрээнд нийт 29 объектод, түүнээс 2015 оны төлөвлөгөөнд тусгасны дагуу 11, гомдол, мэдээллийн дагуу 3, хүний эрхийн нээлттэй өдрийн хүрээнд 11, хамтран ажиллах санамж бичгийн дагуу 3, төлөвлөгөөт бус 1 хяналт шалгалтыг тус тус зохион байгуулсан байна. Үүнд:

№	Шалгалт хийсэн объект	Дүн	Авсан арга хэмжээ
1.	ШШГЕГ-ын харьяа хорих анги	9	Хүний эрх, эрх чөлөөг зөрчиж болзошгүй шалтгаан, нөхцлийг арилгуулахаар ЗӨВЛӨМЖ, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар холбогдох албан тушаалтанд тус тус ШААРДЛАГА хүргүүлж хуулийн хугацаанд хариу ирүүлсэн байна.
2.	Цагдан хорих байр	5	
3.	Баривчлах, саатуулах байр	6	
4.	Хил хамгаалах газар, Цэргийн ангийн сахилгын байр, Зэвсэгт хүчний жанжан Штаб	3	
5.	Сургуулийн өмнөх боловсрол олгох цэцэрлэг	5	Шаардлага
6.	Хувийн хэвшил	1	Шаардлага

Төрийн байгууллагуудтай байгуулсан Хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд төлөвлөгөө гарган хамтарсан хяналт шалгалт зохион байгуулж ажиллав. Үүнд:


а/ Хил хамгаалах ерөнхий газартай 2010 оны 12 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан Санамж бичгийн хүрээнд 2015 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Хөвсгөл аймаг дахь Хилийн цэргийн 0257 дугаар ангид ажиллагсдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, зөрчлийг арилгуулахаар тус ангийн даргад Комиссын гишүүний шаардлагыг хүргүүлсэн байна.

б/ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартай 2014 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр байгуулсан Санамж бичгийн 2.2.10 дахь хэсэгт заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 9 хорих анги, 5 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд хяналт шалгалт зохион байгуулсан байна.

в/ Зэвсэгт хүчний жанжин штабтай 2014 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр байгуулсан Санамж бичгийн 2.2.10 дахь хэсэгт заасны дагуу 032 дугаар ангийн сахилгын хорих байрны орчин нөхцөлд хяналт шалгалт явуулж, шалгалтын дүнгийн хурлыг зохион байгуулж, Комиссын гишүүний зөвлөмж хүргүүлсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд тэгш хамруулж буй эсэхийг тодорхойлох зорилгоор тусгай хэв шинжийн улсын цэцэрлэгийн нөхцөл, үйл ажиллагаанд Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамтай хамтран 2015 оны 10 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд Сургуулийн өмнөх боловсрол олгох тусгай хэв шинжтэй 4 цэцэрлэгт (10, 186 дугаар улсын цэцэрлэг, Бяцхан сувд, Энэрлийн түүчээ хувийн цэцэрлэг) суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилтэд хяналт шалгалт зохион байгуулж, зөрчлийг арилгуулахаар Комиссын гишүүний шаардлагыг хүргүүлсэн.


Комиссоос хийсэн хяналт шалгалтын тоон мэдээллийг өмнөх онуудтай харьцуулсныг графикаар харуулбал:




Шаардлага: Комисс 2015 онд нийт 37 аж ахуйн нэгж байгууллагад Комиссын гишүүний шаардлага хүргүүлсэн байна.

Зөвлөмж: Комисс 2015 онд нийт 40 аж ахуйн нэгж байгууллагад Комиссын гишүүний зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Шаардлагын тоон мэдээллийг өмнөх онуудтай харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна. Үүнийг графикаар харуулбал:



Зөвлөмжийн тоон мэдээллийг өмнөх онуудтай харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна. Үүнийг графикаар үзүүлбэл:



1.3 Хууль тогтоомж, бодлого хөтөлбөр, тогтолцоог боловсронгуй болгоход чиглэсэн арга хэмжээ

Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн төсөлд 2015 онд ажлын хэсгээр ажиллаж 24 саналыг холбогдох ажлын хэсэг, хууль санаачлагчдад хүргүүлэв. Үүнд:

№	Хуулийн төсөл	Хэнд	Огноо
1	Зөрчлийн тухай, Гэмт хэргийн тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслүүд	Хууль зүйн сайд Д.Дорлигжав	2015.01.25
2	Шүүмжлэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл	УИХ-ын гишүүн Ц.Оюунгэрэл	2015.01.13 1/31

3	Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга	Хууль зүйн сайд Д.Дорлигжав	2015.01.30. 1/89
4	Зөрчлийн тухай хууль	Хууль зүйн сайд Д.Дорлигжав	2015.01.30. 1/89
5	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Хууль зүйн сайд Д.Дорлигжав	2015.02.13. 1/128
6	Хууль сахиулах ажиллагааны тухай хуулийн төсөл	Хууль зүйн сайд Д.Дорлигжав	2015.02.16. 1/135
7	Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Бэлтгэл хүчний цэргийн тухай, Мөрдөх албаны тухай, Тахарын албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд	Хууль зүйн яамны төрийн нарийн бичгийн дарга Ж.Баярцэцэг	2015.02.24. 4/149
8	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан боловсруулсан “Авлигатай тэмцэх, хариуцлага, шударга ёсыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай” УИХ-ын тогтоолын төсөл	Хууль зүйн сайд Д.Дорлигжав	2015.03.02. 1/171
9	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл	Хууль зүйн сайд Д.Дорлигжав	2015.03.06. 1/187
10	Хохирлын сангийн тухай хуулийн төсөл	Хууль зүйн сайд Д.Дорлигжав	2015.03.09. 3/193
11	Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Хууль зүйн сайд Д.Дорлигжав	2015.04.27. 1/327
12	Прокурорын байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Хууль зүйн сайд Д.Дорлигжав	2015.05.04. 3/352
13	Хуульчийн эрх зүйн байдал, хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Өмгөөллийн тухай хуулийн төсөл, Нотариатын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Хууль зүйн сайд Д.Дорлигжав	2015.05.13. 1/384
14	Ялаас чөлөөлөх өвчний жагсаалт, хүнд өвчтэй ялтанд эмнэлгийн байгууллагын туслалцаа үзүүлэх журмын төсөл	Хууль зүйн сайд Д.Дорлигжав	
15	Олон улсын гэрээний тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/	Гадаад хэргийн сайд Л.Пүрэвсүрэн	2015.06.15. 1/451
16	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэ	2015.06.19. 1/474
17	Өршөөл үзүүлэх тухай хуулийн төсөл	Хууль зүйн сайд Д.Дорлигжав	2015.07.06. 1/531
18	Гүйцэтгэх ажлын тухай хуулийн төсөл	Хууль зүйн сайд Д.Дорлигжав	2015.07.08. 1/538
19	“Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах цогц бодлогыг батлах тухай” УИХ-ын тогтоолын төсөл	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэ	2015.08.21. 1/629
20	Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төсөл	УИХ-ын гишүүн Н.Батбаяр болон нэр бүхий 7 гишүүн	2015.10.07 1/721
21	Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга	УИХ-ын гишүүн Г.Батхүү	2015.10.16. 1/734
22	Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга	Хууль зүйн сайд Д.Дорлигжав	2015.11.23. 1/830

23	Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Макаогийн Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл	Хууль зүйн сайд Д.Дорлигжав	2015.12.02. 1/853
24	"Ногоон хөгжлийн бодлого"-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний Засгийн газрын тогтоолын төсөл	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Н.Батцэрэг	2015.12.04. 1/862

1.4 Судалгаа, дүн шинжилгээ

Ази-Номхон далайн ХЭҮБ-уудын форум, Эрүү шүүлтийн эсрэг хорооноос хэрэгжүүлж буй "Эрүү шүүлтийн эсрэг элчин сайд" хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн удирдамжийн төслийг 2015 оны 1-6 сард боловсруулав. Төслийн зөвлөх Марко Монатай тогтмол хамтран ажиллаж, Швейцарийн УСҮМ-ын боловсруулсан гарын авлага, санал асуулгын хуудаст судалгаа хийж ажиллалаа. Төслийн хүрээнд Комиссын ажлын албаны ажилтнуудад сургалт хийв. Зөвлөх Марко Мона удирдамжийн төслийг өндрөөр үнэлсэн бөгөөд 2015 оны 8 дугаар сарын 28-ны өдөр болсон Ази-Номхон далайн бүсийн хүний эрхийн үндэсний байгууллагуудын 2 жил тутмын бага хуралд Комисс төслийн талаар мэдээлэл хийж, 8 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд ээлжит хуралд оролцож төслийн үйл явцын талаар илтгэл тавив.

Хууль зүйн туслалцаа авах эрхээ хангалттай эдэлж чадаж байгаа эсэх, сэжигтэн, яллагдагч түүнд холбогдох эрүүгийн хэрэг үүсгэснээс эхлэн шүүхэд хэргийг шилжүүлэх хүртэл хугацаанд өмгөөлөгчөөс үзүүлсэн хууль зүйн туслалцаа нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, шуурхай, бүрэн, тууштай байдал, нууцыг чанд хадгалах, зарчимд нийцэж байгаа эсэхийг судалгаандаа тусгав. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Цагдан хорих 461 дүгээр ангид 6 дугаар сард ажиллаж тандалтын судалгаа авав. Мөн холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийж тухайн өдөр хоригдож байсан 640 хоригдогчийг хамруулж, санал асуулга авлаа. Сонгон авсан 12 хоригдогчтой ганцаарчилсан ярилцлага хийв. Цагдан хорих газар дээр хууль зүйн туслалцаа авах эрхтэй холбоотой мөрдөгдөж буй баримт бичигт дүн шинжилгээ хийж, судалгаандаа тусгав. 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр "Цагдан хоригдож буй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хууль зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилт" сэдэвт судалгааны дүнг танилцуулах уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж ХЭҮК, ШШШЕГ, Хуульдын болон Өмгөөлөгчдийн холбооны төлөөлөл нийт 24 хүн оролцов.

Сонгон авсан байгууллага дээр хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх хүрээнд Баянхонгор аймгийн Баян-Овоо, Галуут, Жаргалант сум, Дорноговь аймгийн Айраг сумдад ажиллав. Тухайн орон нутагт бичил уурхай эрхэлж буй иргэд, сумдын иргэд, малчид, сумын Засаг дарга, ИНХ-ын дарга, төрийн албан хаагчид, цагдаа, эмнэлгийн ажилтнууд, иргэний нийгмийн байгууллагууд оролцож уулзалт, ярилцлага зохион байгуулж, санал асуулга авах, үйл ажиллагаатай нь газар дээр очиж танилцах ажлыг 5 дугаар сарын 6-10, 6 сарын 4-5-ны өдрүүдэд хийлээ.

Энэхүү нөлөөллийн үнэлгээгээр бичил уурхай дахь хүний эрхийн төлөв байдлыг тодорхойлох, бичил уурхайн үйл ажиллагаа нь тухайн орон нутгийн иргэдийн хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хэрхэн нөлөөлж байгааг судлах, орон нутгийн удирдлага, төрийн албан хаагчдын зүгээс хүний эрхийн чиглэлээр явуулж буй үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, нэн ялангуяа, иргэдийн амьжиргааны хүрэлцээтэй түвшинд аж төрөх, оршин суух газраа чөлөөтэй сонгох, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах, шийдвэр гаргах үйл явцад оролцох эрхийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, бичил уурхайн үйл ажиллагаанаас шалтгаалан хүний эрхийн зөрчил, түүний шалтгаан, уул

уурхайн үйлдвэрлэлийн байгаль орчин, уламжлалт бэлчээрийн мал аж ахуйд үзүүлж буй нөлөөллийг судлав. Нөлөөллийн үнэлгээний тайланг Хүний эрхийн Үндэсний Комиссын Захиргаа хамтын ажиллагааны хэлтсийн дарга Ч.Алтангэрэл 2015 оны 12 дугаар сарын 2-ны өдөр "Бичил уурхайг албажуулах замаар бичил уурхайчдын нийгмийн хамгааллыг сайжруулах нь" сэдэвт Үндэсний чуулган дээр танилцуулсан болно.

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийг боловсронгуй болгох судалгааг хийж гүйцэтгэв. Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Монголын ахмадын холбоо, Монголын ахмадын чөлөөт холбооноос мэдээлэл авч судалгаанд ашиглалаа.

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн зохицуулалтын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх; <u>Аргачлал:</u> Монгол Улсын хууль тогтоомжоор ахмад настны нийгмийн хамгааллын харилцааг зохицуулж буй байдал, 1992 оноос хойшхи эрх зүйн зохицуулалтын өөрчлөлт, шинэчлэлтийг харьцуулах, хүчин төгөлдөр үйлчлэж буй Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийг хэрэглэж, хэрэгжүүлж буй байдалд дүн шинжилгээ хийх
Ахмад настнууд нийгмийн хамгаалалд хамрагдахад тулгарч буй бэрхшээл, өнөөгийн практикийг судалж, дүн шинжилгээ хийх; <u>Аргачлал:</u> Зорилтот бүлгийнхэнтэй ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагыг төлөвлөсөн асуумжийн дагуу, санал асуулгыг боловсруулсан санал асуулгын хуудсаар авч, дүнг нэгтгэх.
Ахмад настны эдийн засаг, нийгэм, соёлын эрх болон тэдний эрхийг хамгаалах талаарх олон улсын зарчим, эрх зүйн зохицуулалтыг судлах <u>Аргачлал:</u> Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд ахмад настны эрхийг хангах талаар хэрхэн зохицуулсныг болон олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээнд тэдний нийгмийн хамгалалын эрхийн асуудлыг хэрхэн тунхагласныг эрх зүйн акт, түүний зүйл, хэсэг бүрээр судлах.
Гадаадын зарим улсуудын ахмад настны нийгмийн хамгааллын асуудлыг зохицуулсан хуулийн зохицуулалтыг харьцуулан судалж, дүн шинжилгээ хийх; <u>Аргачлал:</u> Сайн туршлага бүхий 5-7 улсыг сонгон(тэр дундаа Скандинавын болон Баруун Европын улс орнууд, Япон, БНСУ зэрэг Азийн зарим орнууд) ахмад настны нийгмийн хамгааллын асуудлаарх эрх зүйн зохицуулалт, практик, туршлагыг судлах.

Судалгааны дүнг 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Комиссын дарга, гишүүдэд танилцуулав.

2001 оноос хойш Комиссын илтгэлээр өгөгдсөн бүх санал, зөвлөмжийн бүртгэлийг цахим санд оруулж, тэдгээрийг УИХ-аас хэрхэн шийдвэрлэсэн, Засгийн газар өгсөн чиглэлийн дагуу хэрхэн ажиллаж байгаа талаарх мэдээллийг уг бүртгэлд оруулав. 2002-2013 оны Комиссын илтгэлээр гаргасан санал зөвлөмжийн түүврээр нэгдсэн сан бүрдүүлж, нийт 223 санал зөвлөмжийн түүвэр хийсэн байна. Мэдээллийн сан илтгэлийн сэдэв, Комиссын дэвшүүлсэн санал зөвлөмж, УИХ-аас авсан арга хэмжээ, хэрэгжилтийн байдал зэрэг мэдээллийг агуулж байгаа болно. Санал зөвлөмжийн хэрэгжилтийн байдлыг 2010 оноос хойшхи жил бүрийн илтгэлд тусгасан хэрэгжилтийн байдлаар бүрэн хэрэгжсэн, хагас хэрэгжсэн, хэрэгжээгүй гэсэн үзүүлэлтээр гаргав.

Гомдол, хяналт шалгалт, Бодлогын дүн шинжилгээ, судалгаа, хүний эрхийн боловсролын цахим санг баяжуулан дараах бүтэцтэйгээр тогтмол ажиллуулж байна. Үүнд:

1. Сургалт
2. Судалгаа
3. Дүн шинжилгээ
4. Илтгэлийн санал, зөвлөмж,
5. Тараах материал
6. Сэтгүүлчдийн клубийн бүртгэл
7. Нээлттэй өдрийн бүртгэл
8. Номын сангийн бүртгэл

- 9. Хэвлүүлсэн ном
- 10. Цуврал лекцийн бүртгэл


1.5 Хүний эрх зөрчсөн тухай гомдлыг хүлээн авч, шалгаж шийдвэрлэх

Энэ ажлын хүрээнд 2015 онд Комисс иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн 623 гомдлыг хүлээн авч, ажиллагаа хийсэн болно.


Нийт 623 гомдлоос 104 гомдол буюу 16,6 хувь нь орон нутгаас ирүүлсэн байна. Мөн нийт гомдлын 49 хувь нь ШШГЕГ-ын харьяа Хорих ангид ял эдэлж буй ялтан, Цагдан хорих ангид хоригдож буй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс ирүүлсэн гомдол эзэлж байна. Үүнд:

- Цагдан хорих 0461 дүгээр ангид хоригдогчоос 229 гомдол буюу 36,7 хувь
- Орон нутгийн Цагдан хорих байранд хоригдогчоос 32 гомдол буюу 5,1 хувь
- Хорих ангид ял эдэлж буй ялтнаас 43 гомдол буюу 6,9 хувь

Гомдлын тоон үзүүлэлтийг графикаар үзүүлбэл:




Комисст ирүүлсэн гомдлын тоон мэдээллийг өмнөх жилүүдтэй харьцуулахад багассан үзүүлэлттэй байна. Үүнийг графикаар үзүүлбэл:



Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсний улмаас учирсан хохирлыг арилгуулах, сэргээн эдлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах хүрээнд Дорнод аймгийн Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч 2015 оны 02 дугаар сарын 16-ны өдөр “Тус сумын иргэд гэр бүлээ албан ёсоор батлуулахад гэр бүлийн хүлээх үүрэг хариуцлага, өмчийн болоод харилцааны эрх тэгш байдлыг хангасан хамтын хариуцлагын гэрээ байгуулах...” тухай А/38 дугаар захирамж гаргасан нь Монгол Улсын Үндсэн хууль, Гэр бүлийн тухай хуулиар баталгаажуулсан иргэд сайн дурын үндсэн дээр гэр бүл болох, гэрлэлтээ бүртгүүлэх эрхийг хууль бусаар хязгаарласан олон улсын хүний эрхийн гэрээ, конвенц, Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийг зөрчсөн байх тул Хэрлэн сумын Засаг даргын 2015 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/38 дугаар захирамжийг хүчингүй болгуулахаар Дорнод аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан.

Комиссоос гаргасан нэхэмжлэлийн тоон мэдээллийг графикаар үзүүлбэл:




Хүний эрхийн зөрчилтэй холбоотой эрүү, иргэн, захиргааны хэрэг, маргааны асуудлаар биечлэн, утсаар болон цахим хэлбэрээр хууль зүйн зөвлөгөө өгөх хүрээнд 2015 онд Комисс утсаар 164, цахимаар 7, биечлэн 1370 буюу нийт 1541 хүнд 631 цаг 46 минутын хууль зүйн зөвлөгөө өгсөн байна. Үүнээс Улаанбаатар хотод утсаар 56, цахимаар 3, биечлэн 296 буюу нийт 355 иргэнд 6720 минутын буюу 112 цагийн хууль зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.

	Нийт хандсан тоо	Хэлбэр			Нийт минут
		Утас	Цахим	Биечлэн	
Улаанбаатар	355	56	3	296	6720
Архангай	32	0	0	32	475
Баян-Өлгий	42	3	0	39	490
Баянхонгор	26	4	0	22	520
Булган	69	4	0	65	1333
Говь-Алтай	93	6	0	87	2712
Говьсүмбэр	54	4	0	50	1650
Дархан-Уул	67	6	1	60	2079
Дорноговь	59	0	0	59	1960
Дорнод	24	0	0	24	960
Дундговь	50	5	0	45	756
Завхан	50	7	2	41	854
Орхон	45	1	0	44	1090
Өвөрхангай	45	0	0	45	1155

Өмнөговь	43	4	0	39	2189
Сүхбаатар	48	0	0	48	1131
Сэлэнгэ	61	2	0	59	1592
Төв	60	7	0	53	2474
Увс	72	24	0	48	2042
Ховд	51	7	0	44	2560
Хөвсгөл	35	4	0	31	-
Хэнтий	160	20	1	139	3164

Хууль зүйн зөвлөгөөг өмнөх онуудтай харьцуулбал өссөн үзүүлэлттэй байна. Үүнийг графикаар харуулбал:



Гомдол, хяналт шалгалтын ажлын чанар, үр дүнг нэмэгдүүлэх, бүртгэл мэдээллийн санг тогтмол ажлын хүрээнд хөтлөх ажилтнууд абль программыг ашиглаж хэвшсэн байна.

ХОЁР. ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1 Тодорхой бүлэгт чиглэсэн хүний эрхийн сургалт, уулзалт

2015 онд нийт 72 удаагийн, 276.4 цагийн сургалтыг 3227 оролцогчид зохион байгуулав.

	Огноо	Сургалтын сэдэв	Оролцогчид	Цаг	Тоо
1	15.01.09	ХЭҮК-ын үйл ажиллагааны танилцуулга Хүний эрхийн тухай үндсэн ойлголт Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх	Орхон аймгийн нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн ажилтнууд	2	30
2	15.01.14	Комиссын үйл ажиллагааны танилцуулга	Булган аймгийн эмэгтэйчүүдийн холбооны гишүүд, дэмжигчид	2	15
3	15.01.21	ХЭҮК-ын үйл ажиллагааны танилцуулга Хүний эрхийн тухай үндсэн ойлголт Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх	Баянзүрх дүүргийн Баянзүрх Нэг зүрх төвийн ажилтнууд	2	25
4	15.01.26	ХЭҮК-ын үйл ажиллагааны танилцуулга Хүний эрхийн тухай үндсэн ойлголт Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх	Хан-Уул дүүргийн Иргэний танхим	2	21

5	15.01.29	ХЭҮК-ын үйл ажиллагааны танилцуулга Хүний эрхийн тухай үндсэн ойлголт Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх	Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс	2	11
6	15.02.05	Хүний эрхэд суурилсан хандлага ба жендэрийн тэгш байдал	Швейцарийн хөгжлийн агентлагийн ажилтнууд	8	12
7	15.02.16	Хүний эрхэд суурилсан хорих байгууллага, хорих байгууллагын менежмент	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тогтоол гүйцэтгэх газрын ажилтнууд	1	19
8	15.02.05	Хүн худалдаалах гэмт хэрэг ба хүний эрх	Дорноговь, Замын үүд, Өмнөговь, Дорнод, Сэлэнгэ аймгийн шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөн байцаагч, тахарын албаны гэрч хохирогчийг хамгаалах газар, аймгийн хууль зүйн хэлтсийн ажилтнууд	1,5	30
9	15.02.16	Хүний эрхийн үндсэн ойлголт, Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд	ШШГЕГ-ын харьяа хорих 409-р ангийн албан хаагч, ажилтнууд	2	48
10	15.03.18	Хүний эрхэд суурилсан хандлага	Улсын бүртгэлийн ерөнхий газрын удирдах албан тушаалтнууд	1	51
11	15.03.26	Гэр бүлийн хүчирхийлэл	Хууль сахиулах их сургуулийн сонсогч нар	2	21
12	15.04.01	ХЭҮК-ын танилцуулга	Энэрэл сургууль	0,5	26
13	15.04.09	ХЭҮК-ын танилцуулга	Энэрэл сургууль	0,5	12
14	15.04.10	Хүний эрхэд суурилсан хандлага, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нь, ЭБША-нд хүний эрхийг хангах нь	ЦЕГ-ын Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх газар	3	21
15	15.04.24	Хэвлэл мэдээлэл ба хүний эрхэд суурилсан хандлага	Сэтгүүлчид	16	33
16	15.04.28	ХЭҮК-ын танилцуулга	Отгонтэнгэр ИС-ийн оюутнуудад	3	60
17	15.05.04	Төрийн үйлчилгээн дэх хүний эрхэд суурилсан хандлага	Аймгийн Татварын газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн ажилтнууд	4	48
18	15.05.04	Төрийн үйлчилгээн дэх хүний эрхэд суурилсан хандлага	Аймгийн ИТХ, ЗДТГ-ын ажилтнууд, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн эрхлэгч, менежер, нэгдсэн эмнэлгийн ажилтнууд	5	36
19	15.05.05	Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нь	Хууль сахиулах их сургуулийн сонсогч нар	2	80
20	15.05.05	Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрхийг хангах нь	Шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх зэрэг хууль сахиулах байгууллагын ажилтнууд	4	36

21	15.05.05	Хүний эрхэд суурилсан хандлага	ЗХЖШ-ын 339 дүгээр ангийн алба хаагчид	4	73
22	15.05.06	Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нь	Хууль сахиулах байгууллагын албан хаагчид	8	40
23	15.05.07	ХЭҮК-ын танилцуулга	Сутай дээд сургуулийн оюутнуудад	2	25
24	15.05.11	ХЭҮК-т гомдол шийдвэрлэх ажиллагаа, практик	Төрийн бус байгууллагуудын төлөөлөл	1	25
25	15.05.11	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц	Төрийн бус байгууллагуудын төлөөлөл	2	25
26	15.05.13	Мөрдөн байцаалтын явцад хүний эрхийг хангах нь	Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах хэлтсийн ажилтнууд	5	10
27	15.05.18	Хүний эрхэд суурилсан төрийн үйлчилгээ	Архангай, Аймгийн ИТХ, ЗДТГ-ын болон бусад иргэдэд үйлчлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны албан хаагчид, ЕБС-ийн менежерүүд Сум, багийн Засаг дарга, Нийгмийн ажилтан, Хэсгийн ахлагч нар	8	139
28	15.05.19	Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрхийг хангах нь	Архангай аймгийн Цагдаагийн газар, ШШГА, Тахарын алба, Прокурорын газар, Шүүх зэрэг хууль сахиулах байгууллагын албан хаагчид	8	44
29	15.05.21	Хүний эрхэд суурилсан төрийн үйлчилгээ	Хөвсгөл, Аймгийн ИТХ, ЗДТГ-ын болон бусад иргэдэд үйлчлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны албан хаагчид, ЕБС-ийн менежерүүд Сум, багийн Засаг дарга, Нийгмийн ажилтан, Хэсгийн ахлагч нар	8	101
30	15.05.22	Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрхийг хангах нь	Хөвсгөл аймгийн Цагдаагийн газар, ШШГА, Тахарын алба, Прокурорын газар, Шүүх зэрэг хууль сахиулах байгууллагын албан хаагчид	8	45
31	15.05.24	Хүний эрхэд суурилсан хандлага	Хөвсгөл аймаг дахь Цагааннуурын застав	6	13
32	15.05.25	Хүний эрхийн ерөнхий ойлголт Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт	Хорих 421 дүгээр ангийн албан хаагчид	1	36
33	15.05.25	Хүний эрхэд суурилсан хандлага	Хөвсгөл аймаг дахь Улаан-Уулын застав	6	15
34	15.05.26	Хүний эрхэд суурилсан хандлага	ХХЕГ-ын харьяа 0257-р анги	7	43
35	15.05.27	Хорих байгууллага ба хүний эрх	Хорих 401 дүгээр ангийн албан хаагчид	1	15
36	15.05.27	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн зохицуулалт ХЭҮК-т гомдол шийдвэрлэх ажиллагаа	Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооны гишүүд	2	31

37	15.06.08	Хүний эрхэд суурилсан төрийн үйлчилгээ	Дорноговь аймгийн ИТХ, ЗДТГ-ын болон бусад иргэдэд үйлчлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны албан хаагчид, ЕБС-ийн менежерүүд Сум, багийн Засаг дарга, Нийгмийн ажилтан, Хэсгийн ахлагч нар	8	100
38	15.06.08	Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрхийг хангах нь	Дорноговь аймгийн Цагдаагийн газар, ШШГА, Тахарын алба, Прокурорын газар, Шүүх зэрэг хууль сахиулах байгууллагын албан хаагчид	4	50
39	15.06.08	Хүний эрхэд суурилсан төрийн үйлчилгээ	Говьсүмбэр аймгийн ИТХ, ЗДТГ-ын болон бусад иргэдэд үйлчлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны албан хаагчид, ЕБС-ийн менежерүүд Сум, багийн Засаг дарга, Нийгмийн ажилтан, Хэсгийн ахлагч нар	8	100
40	15.06.09	Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрхийг хангах нь	Говьсүмбэр аймгийн Цагдаагийн газар, ШШГА, Тахарын алба, Прокурорын газар, Шүүх зэрэг хууль сахиулах байгууллагын албан хаагчид	4	50
41	15.06.15	Комиссын үйл ажиллагааны танилцуулга Хүний эрхийн үндсэн ойлголт Хөдөлмөрлөх эрхийн зарим ойлголт Судалгааны санал, зөвлөмж	МҮЭХ-ны гишүүд, дэмжигчид	1,5	60
42	15.06.18	Хүний эрхийн үндсэн ойлголт Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн онцлог, хэрэгжилт Жендэрийн тэгш байдал Тусгай мэх, арга хэрэгсэл ашиглах нь	Амгалан мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	3	21
43	15.06.18	Хүний эрхийн үндсэн ойлголт	ХСИХ-ийн сонсогч-төгсөгчид	1	200
44	15.06.19	Хүний эрхийн үндсэн ойлголт (эрүү шүүлт, бэлгийн цөөнхийн жишээнд тулгуурлан)	ЦЕГ-ын Авто баазын ажилтнууд	1	79
45	15.06.25	Гэр бүлийн хүчирхийлэл	ЦЕГ-ын албан хаагчид	2	35
46	15.07.02	Хүний эрхийн үндсэн ойлголт, Хүний эрхэд суурилсан хандлага, Хүний эрхийн олон улсын гэрээ, ХЭҮК-т гомдол гаргах нь	ЗХЖШ-ын Энхийг сахиулах ажиллагааны оролцогчид	4	150
47	15.09.04	Хүний эрхийг хангах үндэсний механизм	Баянзүрх дүүргийн цагдаагийн газрын ажилтнууд	2	21
48	2015.09.04	Хүний эрхийн үндсэн ойлголт, Хүний эрхэд суурилсан хандлага	Сонгинохайрхан дүүргийн Цагдаагийн алба хаагчид	1	105
49	2015.09.10	Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа ба хүний эрх	Төв орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн мөрдөн байцаах хэлтэс, тасгийн дарга нар	1	60
50	2015.09.07	Төрийн үйлчилгээн дэх хүний эрхэд суурилсан хандлага,	Говь-Алтай аймгийн ЗДТГ-ын болон татвар, нийгмийн даатгал, нийгмийн халамж, хөдөлмөр, иргэний шилжилт хөдөлгөөн, бүртгэлийн хэлтсийн ажилтнууд	4	43

51	2015.09.07	Төрийн үйлчилгээн дэх хүний эрхэд суурилсан хандлага,	Говь-Алтай аймгийн сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч, менежер, нийгмийн ажилтан, нэгдсэн эмнэлгийн ажилтнууд	4	33
52	2015.09.08	ЭБША дахь хүний эрх	Говь-алтай аймгийн хууль сахиулах байгууллагын ажилтнууд	4	42
53	2015.09.11	Хөдөлмөрлөх эрх	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ажилтнууд	1	45
54	15.10.15	Хүний эрхэд суурилсан хандлага	ОБЕГ-ын албан хаагчид	8	40
55	15.10.15	Хүний эрхийг хангах үндэсний механизм	Хууль сахиулах их сургуулийн сонсогч нар	4	30
56	15.10.15	Хүний эрхийн үндсэн ойлголт	Хорих 411 дүгээр ангийн албан хаагчид	8	81
57	15.10.16	Хүний эрх, эрх чөлөөний талаарх Үндсэн хуулийн заалтуудын утга агуулга	Хууль зүйн яамны шинээр томилогдсон ажилтнууд	3	25
58	15.10.16	Хүний эрхийн үндсэн ойлголт, сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн эрүүл мэндээ хамгаалуулах эрх	Сэтгэцийн эмгэг судлалын үндэсний төвийн ажилтнууд	1,5	85
59	15.11.03	Хүний эрх ба хорих байгууллага	ШШГЕГ-ын харьяа хорих 405-р ангийн албан хаагч, ажилтнууд	3	55
60	15.11.04	Хүний эрхийн ерөнхий ойлголт	МҮЭХ-ны гишүүд, дэмжигчид	2	21
61	15.11.04	Хүний эрхийн ерөнхий ойлголт	Улаанбаатар хотын ЦГ-ын Албадан саатуулах төвийн алба хаагчид	1,4	22
62	15.11.05	Монгол улс дахь хүний эрхийн өнөөгийн нөхцөл байдал	“Хөгжил-Ардчилал” ТББ-ийн гишүүд	2	23
63	15.11.06	Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нь, ЭШЭК-ын Нэмэлт протокол, ҮУСМ, Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа ба хүний эрх, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх олон улсын эх сурвалж	ХЗЯ, ШШГЕГ, ХСИС, УЕПГ	8	25
64	15.11.17	Төрийн үйлчилгээ ба хүний эрх	Нийслэлийн бүртгэлийн газрын ажилтнууд	2	40
65	15.11.16	Хүний эрхэд суурилсан хандлага	461-р ангийн албан хаагчид	2	25
66	15.11.20	Хүний эрхэд суурилсан хандлага	БГД,ХУД, СХД шүүхийн ажилтнууд	2	27
67	15.11.20	Ажлын байрны дарамт шахалт	ИХШХГ-ын ажилтнууд	1	80
68	15.11.26	Хүний эрхэд суурилсан хорих байгууллага, хорих байгууллагын менежмент	ШШГЕГ-ын тогтоол гүйцэтгэх газрын албан хаагчид, Захиргаа, хүний нөөц хариуцсан ажилтнууд	1,5	14
69	15.11.30-12.01	Хүний эрхэд суурилсан хандлага	Бичил уурхай бүхий сумдын ИТХ-ын тэргүүлэгчид	21,5	29
70	15.12.03	Хүний эрхэд суурилсан хандлага	Нийслэл, аймаг дүүргүүдийн нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс, хүүхэд гэр бүл, хөгжлийн хэлтсийн болон бичил уурхай бүхий сумдын нийгмийн халамжийн мэргэжилтнүүд	8,5	51
71	15.12.04	Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм	ШШГЕГ-ын харьяа Насанд хүрээгүйчүүдийн хорих 411 дүгээр ангийн алба хаагчид	1	10
72	15.12.14	Хүний эрхийн үндсэн ойлголт	Улаанбаатар хотын ЦГ-ын	2	35

			Албадан саатуулах төвийн алба хаагчид, саатуулагдсан иргэд		
--	--	--	--	--	--

2015 онд шинээр 8-10 сургагч багшийн гарын авлага бэлтгэхээс 1, 3, 4, 5, 7 дахь гарын авлагуудыг эцэслэж хэвлүүлэв.

№	Гарын авлагын сэдэв
1.	Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө
2.	Амьд явах эрх ба халдашгүй дархан байх эрх
3.	Гэр бүлийн хүчирхийлэл ба хүний эрх
4.	Сурч боловсрох эрх
5.	ХДХВ/ДОХ ба хүний эрх
6.	Бэлгийн цөөнхийн эрх
7.	Шүтэх, эс шүтэх эрх чөлөө
8.	Хөдөлмөрлөх эрх
9.	Үндэстний цөөнхийн эрх

"Бизнес ба хүний эрх" нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах ажлын хүрээнд хэвлэл мэдээллийн хэрэгслээр "бизнес ба хүний эрх" сэдвээр тухай бүр мэдээлэл хийж оролцов. Блүүмберг телевизэд 2015 оны 12 дугаар сарын 9-ны өдөр "Бизнес ба хүний эрх" сэдвээр шууд ярилцлагад Ажлын албаны дарга оролцов.

2.2 Хүний эрхийн сурталчилгаа

Комиссоос өнгөрсөн хугацаанд хэвлүүлсэн номын жагсаалт гаргаж, цахим хэлбэрт оруулан, нэгдсэн бүртгэлийг хийж 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдөр ХЭҮК дээр Хүний эрхийн цахим номын сангийн нээлтийг зохион байгуулав. Нээлтийн ажиллагаанд БСШУЯ-ны Соёлын өвийн хэлтсийн дарга С.Урантөгс, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн захирал, доктор Ц.Мандах болон Монголын Үндэсний номын сан, Улаанбаатар хотын төв номын сан, Хүүхдийн номын ордон, МУИС-ийн номын сан, ХСИС-ийн номын сан, Үндэсний тагнуулын академи, Удирдлагын академи, зэрэг 16 байгууллагын номын сангийн удирдлагууд оролцлоо. Одоогоор тус цахим номын санд 165 ном товхимол, материалыг байршуулаад байна.

Энэ онд Комисс "Хүний эрхийн нээлттэй өдөр" арга хэмжээг 6 аймагт зохион байгуулав. (Говьсүмбэр, Дорноговь, Хөвсгөл, Архангай, Говь-Алтай, Баянхонгор) Баянхонгор аймагт 5 дугаар сарын 4-5 нд, Архангай, Хөвсгөл аймагт 5 дугаар сарын 20-26 нд, Дорноговь, Говьсүмбэр аймагт 6 дугаар сард, Говь-Алтай аймагт 9 дүгээр сард тус тус "Нээлттэй өдөр" арга хэмжээг удирдамжийн дагуу ХЭҮК, аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран Швейцарийн хөгжлийн агентлагийн "Тогтвортой бичил уурхай" төслийн дэмжлэгтэйгээр зохион байгууллаа. Тус аймгуудын Засаг дарга нарт Комиссын гишүүний зөвлөмж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт Комиссын гишүүний шаардлагыг тус тус хүргүүлэв. 2013-2015 оны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, Засаг даргын захирамж зэрэг нийт 3491 эрх зүйн акт хүний эрхийн үндсэн зарчим, хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж, 42 иргэнтэй ганцаарчлан уулзаж, хууль зүйн зөвлөгөө өгч ажиллав. Хууль, хяналтын байгууллагын ажилтнууд болон төрийн захиргааны албан хаагчдад зориулсан 15 удаагийн сургалтыг зохион байгууллаа. Уг сургалтад нийт 856 төрийн албан хаагчид хамрагдав.

Хэзээ	Сэдэв	Хаана, хэнд зориулж	Цаг	Оролцогч
15.05.04	Төрийн үйлчилгээн дэх хүний эрхэд суурилсан хандлага	Баянхонгор аймгийн Татварын газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн ажилтнууд	4	48
15.05.04	Төрийн үйлчилгээн дэх	Баянхонгор аймгийн ИТХ, ЗДТГ-ын	5	36

	хүний эрхэд суурилсан хандлага	ажилтнууд, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн эрхлэгч, менежер, нэгдсэн эмнэлгийн ажилтнууд		
15.05.05	Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрхийг хангах нь	Баянхонгор Шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх зэрэг хууль сахиулах байгууллагын ажилтнууд	4	36
15.05.05	Хүний эрхэд суурилсан хандлага	Баянхонгор ЗХЖШ-ын 339 дүгээр ангийн алба хаагчид	4	73
15.05.24	Хүний эрхэд суурилсан хандлага	Хөвсгөл аймаг дахь Цагааннуурын застав	6	13
15.05.25	Хүний эрхэд суурилсан хандлага	Хөвсгөл аймаг дахь Улаан-Уулын застав	6	15
15.05.26	Хүний эрхэд суурилсан хандлага	Хөвсгөл ХХЕГ-ын харьяа 0257-р анги	7	43
15.05.21	Хүний эрхэд суурилсан төрийн үйлчилгээ	Хөвсгөл аймгийн ИТХ, ЗДТГ-ын болон бусад иргэдэд үйлчлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны албан хаагчид, ЕБС-ийн менежерүүд Сум, багийн Засаг дарга, Нийгмийн ажилтан, Хэсгийн ахлагч нар	8	101
15.05.22	Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрхийг хангах нь	Хөвсгөл аймгийн Цагдаагийн газар, ШШГА, Тахарын алба, Прокурорын газар, Шүүх зэрэг хууль сахиулах байгууллагын албан хаагчид	8	45
15.06.04	Хүний эрхэд суурилсан төрийн үйлчилгээ	Дорноговь аймгийн ИТХ, ЗДТГ-ын болон бусад иргэдэд үйлчлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны албан хаагчид, ЕБС-ийн менежерүүд Сум, багийн Засаг дарга, Нийгмийн ажилтан, Хэсгийн ахлагч нар	8	100
15.06.05	Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрхийг хангах нь	Дорноговь аймгийн Цагдаагийн газар, ШШГА, Тахарын алба, Прокурорын газар, Шүүх зэрэг хууль сахиулах байгууллагын албан хаагчид	4	50
15.06.08	Хүний эрхэд суурилсан төрийн үйлчилгээ	Говьсүмбэр аймгийн ИТХ, ЗДТГ-ын болон бусад иргэдэд үйлчлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны албан хаагчид, ЕБС-ийн менежерүүд Сум, багийн Засаг дарга, Нийгмийн ажилтан, Хэсгийн ахлагч нар	8	100
15.06.09	Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрхийг хангах нь	Говьсүмбэр аймгийн Цагдаагийн газар, ШШГА, Тахарын алба, Прокурорын газар, Шүүх зэрэг хууль сахиулах байгууллагын албан хаагчид	4	50
15.09.07	Хүний эрхэд суурилсан төрийн үйлчилгээ	Говь-Алтай аймгийн ИТХ, ЗДТГ-ын болон бусад иргэдэд үйлчлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны албан хаагчид, ЕБС-ийн менежерүүд Сум, багийн Засаг дарга, Нийгмийн ажилтан, Хэсгийн ахлагч нар	8	99
15.09.08	Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрхийг хангах нь	Говь-Алтай аймгийн Цагдаагийн газар, ШШГА, Тахарын алба, Прокурорын газар, Шүүх зэрэг хууль сахиулах байгууллагын албан хаагчид	4	47

“Хүний эрх” сэтгүүлийн 2015 оны 1 дэх дугаарыг бэлтгэн 2000 хувь, 2015 оны 2 дахь дугаарыг 300 хувь хэвлүүлж сургалт, сурталчилгааны үйл ажиллагаанд ашиглаж байна.

Сэтгүүлийн 1 дэх дугаарыг дараах агуулгаар бэлтгэж хэвлүүлэв.

1	Иргэний шийдэл ТББ “Хүний Эрхэд Нөлөөлөх Байдлын Үнэлгээ: үзэл баримтлал, туршлага, хэрэгцээ”
2	Б.Галдаа “Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд тулгамдаж буй асуудал ба бие даасан хараат бус байгууллага”
3	Л.Банзрагч “Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь гомдол гаргах эрхгүй захирамж”
4	Б.Болорсайхан “Ази, Номхон далайн бүсийн хүний эрхийн байгууллагуудын үүсэл”
5	М.Амарбаяр “Үндсэн хуульд заасан шашин шүтэх эрхийг хамгаалах төрийн оролцоо”
6	З.Өнөржаргал “Нийгмийн халамж хүртэх иргэний эрх, түүний эрх зүйн баталгаа”
7	Т.Ариунаа “Парламентын хүний эрхийн хороо”
8	Л.Отгондорж “Хүүхдэд хүлээлгэх хорих ял: Эрүүгийн эрх зүйн тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам”
9	“Хүний эрхийн олон улсын гэрээнд оролцогч улсуудын бэлтгэн хүргүүлэх илтгэлийн хэлбэр, агуулгын тухай Удирдамжийн эмхэтгэл”
10	Шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэдэх Орон тооны бус зөвлөлийн гишүүн Т.Доржтой хийсэн ярилцлага

Сэтгүүлийн 2 дахь дугаарыг дараах агуулгаар бэлтгэж хэвлүүлэв.

1	Б.Гүнбилэг “Хаврын хурдан морины уралдаан ба хүүхдийн эрх”
2	Г.Агар-Эрдэнэ “Хууль тогтоомжийг олон улсын гэрээтэй нийцүүлэх замаар цэргийн албан хаагчдыг албадан хөдөлмөрөөс хамгаалах нь”
3	Б.Болорсайхан “Хүний эрхийн үндэсний байгууллагуудыг магадлан итгэмжлэх үйл явцад Монгол Улс”
4	Т.Азжаргал “Монгол Улсад Үндсэн хуулийн шүүхийн журмаар Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлага оногдуулах нь”
5	Э.Халиун “Эрх чөлөө хязгаарлах “Гэрийн хорио” ялын эрүүгийн эрх зүйн зохицуулалт”
6	З.Өнөрсайхан “Иргэний харьяалал ба улс орнуудын хууль тогтоомжийн харьцуулалт”
7	Л.Галбаатар “Монгол Улсын Ерөнхийлөгчийн уучлал үзүүлэхтэй холбоотой эрх зүйн зарим асуудал”
8	Савине фон Шорлемер “Хөгжих эрх хувь хүний эрх үү? эсхүл ард түмний эрх үү?”
9	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэтэй хийсэн ярилцлага “Ахмад настны эрхийг хамгаалах тухай хууль зайлшгүй шаардлагатай байна”

“Хүний эрхийн төлөө” сэтгүүлчид клубын уулзалтыг сар бүр тогтмол зохион байгуулж “Хэвлэн нийтлэхэд анхаарах хүний эрхийн асуудлууд”, “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх”, “Хүний эрхийн олон улсын гэрээ, конвенц”, “Ахмад настны эрх, түүний хэрэгжилт” сэдвээр комиссын ажилтнууд болон ОТБЗ-ийн гишүүн мэдээлэл хийв. Түүнчлэн “Хэвлэл мэдээлэл ба хүний эрхэд суурилсан хандлага” сэдэвт сургалтыг Швейцарийн хөгжлийн агентлаг, Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлтэй хамтран 2015 оны 4 дүгээр сарын 24-25-ны өдрүүдэд зохион байгуулж, 26 хэвлэл мэдээллийн байгууллагын 29 сэтгүүлч хамрагдлаа.

2015 оны 11 дүгээр сард хийсэн ээлжит уулзалтад ХЭҮК-ын дарга Ж.Бямбадорж, ХЭҮК-ын ажлын албаны дарга А.Дашдэлэг, ХЭҮК-ын БДШХЭБХ-ийн дарга Г.Агар-Эрдэнэ, Хүний эрхийн төлөөх сэтгүүлчдийн клубын 12 сэтгүүлч оролцов. Уулзалтаар олон улсын хүний эрхийн өдрийг угтаж хийж байгаа ажлын талаар мэдээлэл өгч, цаашид хэрхэн хамтарч ажиллах боломж бололцооны талаар ярилцлаа.

Өдөр тутмын Үндэсний шуудан, Зууны мэдээ сонинд нийтлэл бэлтгэн хэвлүүлэх үйл ажиллагааны хүрээнд тус 2 сонинтой гэрээг шинэчлэн байгуулж, нийтлэл бэлтгэх ажил үүргийн хуваарийг батлан 2 дугаар сараас эхлэн дараах нийтлэлийг хэвлүүлэв. Үүнд:

1. Архангай аймаг дахь Ажлын байрны сул орон тоог нөхөх зар,
 - Зууны мэдээ 2015.02.06 №25(4951)
2. Хүний эрхийн боловсролын арга зүй
 - Зууны мэдээ 2015.02.13 №31(4957)

3. Ахмад настны эрхийг хамгаалах олон улсын механизм
 - Зууны мэдээ 2015.02.27 №39(4965)
 - Үндэсний шуудан 2015.02.27 №37(2220)
4. Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, түүний ач холбогдол
 - Зууны мэдээ сонины 2015.03.06 №45(4971) дугаарт
 - Үндэсний шуудан сонины 2015 оны 03 дугаар сарын 9-ны өдрийн №043(2228)
5. Хүний эрхийн боловсролд номын сангийн гүйцэтгэх үүрэг
 - Зууны мэдээ сонины 2015.03.13 №51 (4977)
 - Үндэсний шуудан сонины 2015.03.16 №048 (2233)
6. Хүний эрхийн үндэсний байгууллага ба иргэний нийгмийн түншлэл, үр дүн
 - Зууны мэдээ сонины 2015.03.20 №56, 57 (4982, 4983)
 - Үндэсний шуудан сонины 2015.03.23 №053 (2238)
7. Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хэрэгжилт Австрали улсад
 - Үндэсний шуудан сонины 2015.04.03 №082(2247)
 - Зууны мэдээ сонины 2015.04.03№62(4994)
8. Хүний эрхийг хамгаалагч-сэтгүүлчдийн эрх
 - Зууны мэдээ сонин 2015.04.10 №73(4999)
 - Үндэсний шуудан сонин 2015.04.10 №067(2252)
9. Ялтны хөдөлмөр, үнэлгээ, ангилал, аргачлал
 - Зууны мэдээ сонины 2015.04.17 №78(5004)
 - Үндэсний шуудан сонин хэвлээгүй
10. Нөхөн үржихүйн эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд хүний эрхийн үндэсний байгууллагын оролцоо
 - Зууны мэдээ сонины 2015.04.24 №83(5009)
 - Үндэсний шуудан сонин 2015.04.27 №073(2263)
11. Тэгш хамруулах боловсрол
 - Зууны мэдээ сонины 2015.05.01 №88(5014)
 - Үндэсний шуудан сонин 2015.05.01 №083(2268)
12. Төрийн алба ба цахим мэдээлэл
 - Зууны мэдээ сонины 2015.05.08 №93(5019)
 - Үндэсний шуудан сонин 2015.05.08 №088(2273)
13. Хүний эрхийн үндэсний байгууллага ба Олон улсын зохицуулах хорооны магадлан итгэмжлэл
 - Зууны мэдээ сонины 2015.05.15 №98(5024)
 - Үндэсний шуудан сонин 2015.05.19 №094(2279)
14. Боловсролын санхүүжилт
 - Зууны мэдээ сонины 2015.05.29 №108(5034)

15. Бизнес ба хүний эрх
 - Зууны мэдээ сонины 2015.06.05 №112(5038)
16. “Ялгаварлан гадуурхалт, үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэрэг ба хүний эрхийн асуудал” 2015.08.07. №158 (5084)
17. “НҮБ-ын зүгээс улсуудад өгсөн зөвлөмж түүнийг хэрэгжүүлж буй туршлагаууд
 - Үндэсний шуудан сонин 2015.08.27. №162 (2347)
 - Зууны мэдээ сонины 2015.08.14. №163 (5089)
18. “Хүний эрхийн Үндэсний Комисс ба Иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаа” нийтлэл
 - Үндэсний шуудан сонин 2015.08.21. №158 (2343)
 - Зууны мэдээ сонины 2015.08.21. №168 (5094)
19. “Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хэрэгжилтийг хянах НҮБ-ын механизм”
 - Зууны мэдээ сонины 2015.09.04. №178 (5104)
20. “Бүс нутгийн хүний эрхийг хамгаалах механизм, түүний ач холбогдол” нийтлэл
 - Зууны мэдээ сонины 2015.09.11. №183 (5109)
21. “Хүний эрхийн Үндэсний Комиссын Ажлын албаны Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын зар”
 - Зууны мэдээ сонины 2015.09.18. №188 (5114)
22. “Олон улсын хүний эрхийг хамгаалах механизм түүний ач холбогдол” нийтлэл
 - Зууны мэдээ сонины 2015.11.06 №223(5149)
23. “Архангай аймаг дахь Хүний эрхийн Үндэсний Комиссын ажилтны ажлын байрны сул орон тооны зар”
 - Зууны мэдээ сонины 2015.11.20 №233(5159)
24. “ЛГБТИ хүмүүсийн эрүүл мэндээ хамгаалуулах эрх”
 - Зууны мэдээ сонины 2015.11.26-ны өдрийн №243(5159)

"Хүний эрх" мэдээллийн хуудасны загварыг шинэчлэн агуулгыг баяжуулж, 2015 оны №01(45)-ыг "Соёмбо принт" ХХК-иар 500 ширхэгийг хэвлүүлэн иргэд, олон нийтэд тараагаад байна. Швейцарийн хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төслийн санхүүжилтээр "Хүний эрх" сурталчилгааны брошурыг задгай болон багцлан тус бүр 2500 хувь нийт 5000 хувийг хэвлүүлэн сурталчилгаанд ашиглаж байна. 2015 онд нийт 11 төрлийн 23000 ширхэг ном гарын авлага хэвлүүлсэн байна. Үүнд:

	Хэвлүүлсэн ном, товхимол	Хэвлүүлсэн он сар өдөр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэл	2015.03.31	2000	2300	4 600 000
2	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэл англи хэлээр	2015.07.20	200	2900	
3	Хүний эрх сэтгүүл 2015/1	2015.03.28	2000	2250	4 500 000
4	Хүний эрх сэтгүүл 2015/2	2015.10.15	300		
5	Хүний эрхийн товч тайлбар толь	2015.06.27	1200	3450	4 140 000

6	Хүний эрхийн эмхэтгэл	2015.06.27	1200	5860	7 032 000
7	5 төрлийн сурталчилгааны брошур	2015.04.16	12500	126.5	1 581 250
8	Шалгах ажиллагааг үр дүнтэй гүйцэтгэх нь	2015.11.25	300	7600	2 280 000
9	Хүний эрхийн боловсрол	2015.11.30	300	7600	2 280 000
10	Олон улсын хүний эрхийн билл (Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хүний эрхийн гэрээний эмхэтгэл)	2015.11.10	2500	2500	6 250 000
11	Хүүхдийн сайн сайхны төлөө шашны бүлгүүдтэй түншлэх нь	2015.10.01	500	5400	2 700 000
	Нийт		23 000		

Олон улсын хүний эрхийн өдрийн арга хэмжээг зохион байгуулах ажлыг зохион байгуулах төлөвлөгөөний дагуу ажил үүргийн хуваарь гаргаж амжилттай зохион байгуулав.

1. “Бидний эрх, Бидний эрх чөлөө, Цаг ямагт” олон улсын хүний эрхийн өдрийн сурталчилгаа

-Комиссын цахим хуудаст шинээр Олон улсын хүний эрхийн өдөр-2015 булан нээж ажиллуулсан.

-Цахим хуудаст болон Зууны мэдээ сонинд Комиссын даргын мэндчилгээ, ХЭДКГ-ын илгээлтийг англи, монгол хэл дээр орчуулан гаргасан.

-Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтын ажиллагаа сэдэвт ээлжит уулзалтын үеэр Комиссоос эрхлэн гаргасан номын үзэсгэлэн гаргаж танилцуулав.

-“Комисс 2001-2015 онд” үйл ажиллагааны самбар – 3 ширхэг

- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт батлагдсны 50 жилийн ойн самбар -3 багана

-2012-2015 онд олон нийтийн лекцэд илтгэл хүмүүсийн самбар -1 ширхэг

-Номын үзэсгэлэнгийн баннер -1 ширхэг

2. “Хүний эрхийн Үндэсний байгууллага – Иргэний нийгмийн түншлэл ээлжит 11 дэх уулзалт”

2015 оны 12 дугаар сарын 08-ны өдөр Бишрэлт зочид буудлын Роял хурлын танхимд "Хүний эрхийн Үндэсний байгууллага – Иргэний нийгмийн түншлэл ээлжит 11 дэх уулзалт"-ыг зохион байгуулав. Уулзалтад дараах илтгэлүүдийг бэлтгэн тавив.

- Олон улсын хүний эрхийн билл ба Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын талаарх илтгэлд тусгагдсан байдал
- Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт, хэлэлцүүлгээр Үндэсний хоёрдугаар илтгэлийг хэлэлцэн НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлөөс Монгол Улсад өгсөн зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь
- “Тогтвортой хөгжил -2030” хөтөлбөр ба Меридагийн Тунхаглал
- Хүний эрхийн цахим номын сангийн танилцуулга

-Уулзалтанд Гадаад хэргийн яамны Хүний эрхийн хэлтсийн дарга Н.Анхбаяр, Нээлттэй нийгэм форум ТББ-ын Хүний эрх, Засаглалын хөтөлбөрийн менежер Б.Хишигсайхан, “Оюу толгойн хяналт” ТББ-ын гүйцэтгэх захирал, ХЭҮК-ын Орон тооны бус зөвлөлийн гишүүн Д.Сүхгэрэл, Глоб Интернейшнл ТББ-ын тэргүүн Х.Наранжаргал нар илтгэл тавьж оролцов.

-Уулзалтанд оролцогчдад шинээр гаргасан ном, гарын авлага (ОУ-ын ХЭ-ийн билл, ХЭ-ийн боловсрол, Хүний эрх сэтгүүл, Хүүхдийн сайн сайхны төлөө шашны бүлгүүдтэй түншлэх нь гарын авлага)-ын багц тараасан болно.

Уулзалтад УИХ-ын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга Ё.Отгонбаяр, ХЭҮК-ын дарга Ж.Бямбадорж, ХЭҮК-ын гишүүд, Хүнс хөдөө аж ахуйн яам, Хууль зүйн яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Эрүүл, мэнд спортын яам, Уул уурхайн яам, Аж үйлдвэрийн яам, Хөдөлмөрийн яам, Гадаад хэргийн яам, Батлан хамгаалахын яам, БСШУЯ, Барилга, хот байгуулалтын яам, Хүүхдийн төлөө үндэсний газар болон Эмнести Интернэшнл ТББ, Хүний хөгжил, эрх ТББ, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо, Монголын Ахмадын Чөлөөт Холбоо, Хүүхдийн эрх хамгааллын төв, Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, Нээлттэй нийгэм форум зэрэг 30 гаруй байгууллагын 100 төлөөлөл оролцов. Харин хуралд урьсан албан тоот байгууллагууд руу явуулсан хэдий ч Авлигатай тэмцэх газар, Сангийн яам, Зам тээврийн яам, Эрчим хүчний яамнаас төлөөлөл ирж оролцсонгүй.

3. Олон улсын хүний эрхийн өдрийг тохиолдуулан “АХА” тэмцээн зохион байгуулав.

2015 оны 12 дугаар сарын 09-ний өдөр Олон улсын хүний эрхийн өдрийг тохиолдуулан Хүний эрхийн Үндэсний Комисс, Хууль сахиулахын их сургуулийн Эрхзүй, нийгмийн ухааны сургуулиас санаачлан их сургуулийн төгсөх дамжааны сонсогчдын дунд "Бидний эрх, Бидний эрх чөлөө, Цаг ямагт" танин мэдэхүйн "АХА" тэмцээнийг зохион байгууллаа.

Уг арга хэмжээнд Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн П.Оюунчимэг, ажлын албаны дарга А.Дашдэлэг, Их сургуулийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, цагдаагийн хурандаа О.Зоригт, Эрхзүй, нийгмийн ухааны сургуулийн захирал, цагдаагийн хурандаа Д.Батбилэг, ХЭҮК-ын ахлах референт Б.Болорсайхан, БДШХЭБ-ын хэлтсийн ажилтан Ж.Гантуяа нар оролцов.

"АХА" тэмцээнд 50 сонсогч оролцож оюун ухаан, мэдлэг чадвараа сорин өрсөлдсөнөөс Цагдаагийн сургуулийн 341-р дамжааны сонсогч Ц.Анхбаяр тэргүүн байр эзэлж, өргөмжлөл, үнэ бүхий зүйл, их сургуулийнхаа магистрын сургалтад суралцах эрхийн бичгээр шагнуулсан юм. Дэд байрт Хилийн сургуулийн 443-р дамжааны сонсогч Б.Төгөлдөр, гуравдугаар байрт Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн 541-р дамжааны сонсогч Ө.Хүрэлшагай, дөрөвдүгээр байрт Хилийн сургуулийн 443-р дамжааны сонсогч Х.Өнөрболд, тавдугаар байрт Цагдаагийн сургуулийн 345-р дамжааны сонсогч Н.Бат-Эрдэнэ нар шалгарч, өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнуулав.

4. “Хүний эрхийн цахим номын сан”-г танилцуулах уулзалт зохион байгууллаа.

2015 оны 12 дугаар сарын 10-ны өдөр ХЭҮК дээр Хүний эрхийн цахим номын сангийн нээлтийг зохион байгуулав. Нээлтийн ажиллагаанд БСШУЯ-ны Соёлын өвийн хэлтсийн дарга С.Урантөгс, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн захирал, доктор Ц.Мандах болон Монголын Үндэсний номын сан, Улаанбаатар хотын төв номын сан, Хүүхдийн номын ордон, МУИС-ийн номын сан, ХСИС-ийн номын сан, Үндэсний Тагнуулын академи, Удирдлагын академи, зэрэг 16 байгууллагын номын сангийн удирдлагууд оролцлоо. Түүнчлэн Улаанбаатар хотод ирсэн байсан 18 аймгийн номын санчдад номын

дээжүүдээ хүргүүлсэн бөгөөд энэхүү уулзалтын үр дүн: БСШУЯ, ШССМТөв манай хүний эрхийн цахим номын сангийн линкийг өөрсдийнхөө байгууллагын вэб хуудсанд холбохоор болов. Мөн Монголын Үндэсний Номын сангаас ХЭҮК-т Батламж гардуулав, Номонд өгөх Таны сэтгэгдэл дэвтэрт 6 хүн сэтгэгдлээ бичиж үлдээв.

5. Хэвлэлийн бага хурал зохион байгуулах

2015 оны 12 дугаарсарын 10-ны өдөр 11:00 цагаас ХЭҮК-оос “Бидний эрх, бидний эрх чөлөө, цаг ямагт” уриан дор тэмдэглэж буй олон улсын хүний эрхийн өдрийг тохиолдуулан хэвлэлийн бага хурал хийлээ. Хуралд ХЭҮК-ын дарга Ж.Бямбадорж, ХЭҮК-ын гишүүд, ажлын албаны дарга, ажилтнууд оролцож мэдээлэл хийж, сэтгүүлчдийн асуултад хариулав.

-2015 онд Хүний эрх, эрх чөлөөг хөндсөн сэдэвт нийтлэл, нэвтрүүлэг тогтмол бэлтгэж, хамтран ажилласан байгууллагад Талархал илэрхийлэх ажлыг зохион байгуулах (Зууны мэдээ сонин, www.gogo.mn сайт, МҮОНТВ-ийн Эрх зүйн хөтөч нэвтрүүлэг, МҮОНРадиоогийн Хурд агентлагт)

6. Хэвлэл мэдээллээр Комиссын дарга, гишүүд, ААД, ажилтнууд оролцох нэвтрүүлэгийн цаг авах, хуваарийг урьдчилан гаргаж, оролцуулах.

Комиссын дарга, гишүүд, Ажлын албаны дарга, хэлтсийн дарга нарыг дараах нэвтрүүлэг, хэвлэлийн ярилцлагад оров.

№	ОНМХ, нэвтрүүлгийн нэр	Мэдээлэл өгсөн хүний нэр, албан тушаал	Сэдвийн агуулга	Огноо, цаг
1	UBS	А.Дашдэлэг	ДОХ туссанаас болж ялгаварлан гадуурхагдсан хүмүүст ХЭҮК хэрхэн тусламж үйлчилгээ үзүүлдэг вэ?	2015.12.01
2	Өдрийн сонин	Ж.Бямбадорж	Хүний эрх	2015.12.01
3	ETV	Л.Дүгэрсүрэн	Халаасны хулгайчдыг зураг хөрөгтэй нь нийтлэх нь хүний эрхийг хэрхэн зөрчиж байгааг	2015.12.02
4	Өнөөдөр сонин	Н.Ганбаяр	Сэтгэл санааны хохирлыг шүүгч үзэмжээрээ л шийдвэрлэж байна	2015.12.11
5	Монголын мэдээ сонин	Ж.Бямбадорж	Хүний эрх, үндсэн хууль	2015.12.02
6	Mongol HD TV	Т.Ихтамир	Ажлын байран дах бэлгийн дарамт	2015.12.03
7	Эрүүл мэндийн Like TV	Ж.Бямбадорж П.Оюунчимэг	“ХүнийэрхийнҮндэснийбайгууллага - Иргэнийнийгмийнтүншлэлээлжит 11 дэхуулзалт”, хүний эрхийн бусад асуудлуудаар	2015.12.08
8	Star TV			
9	TV9 TV			
10	UBS TV			
11	SBN TV			
12	Mongol HD			
13	C1			
14	MNC			
15	VTV			
16	Molor TV			
17	МҮОНР			
18	МҮОНТ			
19	LCN TV			
20	NBS			
21	Eagle TV			
22	MNC	Т.Ихтамир	Хүний эрхийн асуудлаар	2015.12.08 30

				минут
23	TB9	А.Дашдэлэг	Олон улсын хүний эрхийн өдрийг угтан хийсэн ажлуудын талаар	2015.12.08 оройн мэдээний тодруулга булангаар
24	C1	П.Оюунчимэг	Хүний эрхийн асуудлаар	2015.12.08 20 минутын нэвтрүүлэг 14:30
25	UBS TV	Г.Агар-Эрдэнэ	Хүний эрхийн пакт	2015.12.08 зочны ярилцлагын цаг 10 минут
26	Itoim.mn	П.Оюунчимэг	Хүний эрхийн тодруулга	2015.12.08
27	Засгийн газрын мэдээ сонин	Ж.Бямбадорж	Хүний эрхийн олон улсын пактын хэрэгжилт	2015.12.08
28	Bloomberg tv	А.Дашдэлэг	Бизнес ба хүний эрх	2015.12.08
29	Ардчилал сонин	Г.Агар-Эрдэнэ	Олон улсын хүний эрхийн өдрийг угтаж хийсэн ажлуудын талаар	2015.12.09
30	UBS TV	П.Оюунчимэг	Олон улсын хүний эрхийн өдөр, хүний эрхийн асуудлаар	2015.12.10 30 минутын зочны ярилцлагын цаг
31	TV5	А.Дашдэлэг	Олон улсын хүний эрхийн өдөр, хүний эрхийн асуудлаар	2015.12.10 20 минутын ярилцлага
32	ETV	Т.Ихтамир	Олон улсын хүний эрхийн өдөр, хүний эрхийн асуудлаар	2015.12.10 30 минутын ярилцлага
33	Mglradio.com			2015.12.10 30 минутын
34	МҮОНТ	Ж.Бямбадорж	Олон улсын хүний эрхийн өдөр, хүний эрхийн асуудлаар	2015.12.10 30 минут

7. Олон улсын хүний эрхийн өдрийг угтаж шинээр хэвлэн гаргасан ном, гарын авлага

Дараах ном товхимлыг шинээр хэвлүүлэв.

1. Олон улсын хүний эрхийн билл -2500 хувь, санхүүжилтийг ШХА-аас
2. “Шалгах ажиллагааг үр дүнтэй гүйцэтгэх нь” гарын авлага -300 хувь, санхүүжилтийг ШХА-аас
3. “Хүний эрхийн боловсрол” гарын авлага -300 хувь, санхүүжилтийг ШХА-аас
4. “Хүүхдийн сайн сайхны төлөө шашны бүлгүүдтэй түншлэх нь” гарын авлага -500 хувь, санхүүжилтийг НҮБ-ын Хүүхдийн сангаас

2015 оны 12 дугаар сарын 10-ны өдөр ХЭҮК-ын гишүүн П.Оюунчимэг олон улсын хүний эрхийн өдрийг тохиолдуулан УЕПГ, ЦЕГ, ШШГЕГ, Тахарын Ерөнхий Газрын дарга нарт ХЭҮК-ээс эмхлэн гаргасан номнуудынхаа дээжээс гардуулан өгөв.

Улсын Ерөнхий Прокурор, Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх М.Энх-Амгалан: Хүний эрхийн Үндэсний Комисс байгуулагдсан нь хүний эрхийг хамгаалах, эдлүүлэх, хөхиүлэн дэмжихэд үнэтэй хувь нэмэр оруулсан гэж би боддог. Бид бүхэн хүний эрхийг хамгаалах үйлст танай байгууллагатай хамтарч ажиллахдаа ямагт таатай байдаг. Та бүхний өгсөн энэхүү гэрээ конвенцуудыг өдөр тутмын үйл ажиллагаа болон сургалт сурталчилгаандаа ашиглаж хэвшүүлнэ гэв.

Цагдаагийн Ерөнхий Газрын дарга, тэргүүн Комиссар Р.Чингис: Бид бүхний үйл ажиллагааны үндсэн зорилго нь эцсийн эцэст хүний эрхийг хамгаалах, хэв журмыг сахиулах, айх аюулгүй амар тайван орчныг бий болгоход чиглэдэг. ХЭҮК-оос бэлэглэсэн хүний эрхийн эмхтгэл, номуудыг цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хэвшүүлэн ажиллахаа илэрхийллээ.

Улсын Дээд шүүхэд мөн дээрх номыг хүргүүллээ.

ШШГЕГ-ын дэд дарга, Хурандаа Г.Туулхүү: ШШГЕГ-ын хамт олны зүгээс та бүхэнд олон улсын хүний эрхийн өдрийн мэнд хүргэе. Манай байгууллага цаашид шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх чиг үүргээ хэрэгжүүлэхдээ олон улсын хүний эрхийн биллийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахын зэрэгцээ танай байгууллагатай санамж бичгийн хүрээнд үргэлжлүүлэн хамтран ажиллах болно гэв.

Тахарын Ерөнхий Газрын дарга Ц.Азбаяр: Хүний эрхийн Үндэсний Комиссоос биднийг хүндэтгэн ирж шинээр хэвлэсэн ном товхимлынхоо дээжээс гардуулсанд маш их баярлалаа. Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, гэрч хохирогчийг хамгаалах, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хамгаалах үйл ажиллагаандаа хүний эрхийг хүндэтгэж, Монгол Улсын нэгдэн орсон гэрээ конвенцуудыг шударгаар сахин биелүүлж ажиллахаа илэрхийллээ.

2015 онд хүний эрхийн цуврал лекц нийт 6 сэдвийн хүрээнд зохион байгуулав.

- ХҮНИЙ ЭРХИЙН ЦУВРАЛ ЛЕКЦ -

2015 он

					
Д.БАЯРСАЙХАН МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, Хууль зүйн ухааны доктор, профессор “Харьцуулсан эрүүгийн эрх зүй дэх хүний эрх”	Б.ГҮНБИЛЭГ Монголын хуульчдын холбооны олон улсын эрх зүйн хорооны тэргүүн, өмгөөлөгч “Олон улсын эрх зүй ба харилцан хамаарал: Уламжлалт морин уралдаан ба хүүхдийн эрхийн асуудал”	Н.ЛҮНДЭНДОРЖ Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Философийн ухааны доктор, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор “Шударга шүүхээр шүүлгэх эрх”	О.МӨНХСАЙХАН МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Эрх зүй судлалын тэнхимийн багш, Хууль зүйн доктор, Дэд профессор “Хүний эрхийн заалтыг тайлбарлах нь”	Х.НАРАНЖАРГАЛ Глоб Интернэшнл төвийн тэргүүн “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө”	Ц.ЦОГТ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх ба Захиргааны хэргийн шүүх”

Анхны лекцийг “Харьцуулсан эрүүгийн эрх зүй дэх хүний эрх” сэдвээр 2015 оны 3 дугаар сарын 20-ны өдөр МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, хууль зүйн ухааны доктор, профессор Д.Баярсайхан уншлаа. Лекцид нийт 118 хүн оролцов.

2 дахь лекцийг “Олон улсын харьцуулсан эрх зүй ба үндэсний эрх зүйн харилцан хамаарал: Уламжлалт морин уралдаан ба хүүхдийн эрхийн асуудал” сэдвээр 2015 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр Төв аймгийн Зуун мод сумын “Солонго” цогцолборт зохион байгуулав. Лекцийг Монголын Хуульчдын Холбооны Олон улсын эрх зүйн хорооны тэргүүн, Өмгөөлөгч, Хууль зүйн ухааны доктор Б.Гүнбилэг уншлаа. Лекцид нийт 80 орчим хүн оролцсноос 25 нь хурдан морь унаач хүүхэд 55 орчим нь Төв аймгийн Зуун мод суман дахь төрийн байгууллагын ажилтнууд, иргэд, хурдан морь унаач хүүхдийн эцэг эх оролцов.

3 дахь удаагийн лекцийг “Шударга шүүхээр шүүлгэх эрх” сэдвээр 5 сарын 29-ний өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, хууль зүйн шинжлэх ухааны доктор, философийн ухааны доктор, профессор Н.Лүндэндорж уншиж нийт 67 хүн оролцсон.

4 дэх удаагийн лекцийг Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, Хууль зүйн доктор, дэд профессор О.Мөнхсайхан “Хүний эрхийн заалтыг тайлбарлах нь” сэдвээр 6 дугаар сарын 19-ний өдөр уншиж 52 хүн оролцов.

5 дах удаагийн лекцийг 2015 оны 9 дүгээр сарын 18-нд “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө” сэдвээр Глоб Интернэшнл төвийн тэргүүн Х.Наранжаргал уншиж нийт 46 хүн оролцов. Лекцийн чиглүүлэгчээр Захиргаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга Ч.Алтангэрэл ажиллав.

6 дах удаагийн лекцийг 2015 оны 10 дугаар сарын 23-нд “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх ба Захиргааны хэргийн шүүх” сэдвээр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, МУИС-ын Хууль зүйн сургуулийн багш Ц.Цогт лекц уншсан. Лекцид нийт 62 хүн оролцсон болно. Лекцийн Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Н.Ганбаяр удирдан явууллаа.

Комиссын вэб сайтыг Үндэсний дата төвийн серверт шилжүүлэн байршуулж, загвар, дизайныг шинэчлэх ажлыг хийлээ. Комиссын цахим хуудас, олон нийтийн сүлжээг хөтлөн явуулах ажлын хүрээнд ХЭҮК-оос хийсэн бүх судалгааны ажил, Авлигын тэмцэх тухай хууль болон Шилэн дансны тухай хуулийн хүрээнд ил тод булан ажиллуулах, 2014 оны төсвийн аудитын дүгнэлт, хүний эрхийн цуврал лекцийг бүрэн, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэл, ХЭҮК-ын 21 аймаг бүр дэх хуудаст хаяг байршлын мэдээлэл зэрэг нийт 40 гаруй мэдээ мэдээллийг шинээр байршууллаа. Цахим хуудаст зөөвөрлөх, шинэчлэхтэй холбогдон үүссэн зөрчил, алдаа тухай бүрт арилгаж ажиллав.

Комиссын цахим хуудаст 2015 оны 4 дүгээр сараас эхлэн албан ёсоор орон нутгийн ахлах мэргэжилтнүүдэд зориулсан хуудсыг нээн ажиллуулж байгаа бөгөөд оруулсан мэдээний тоон үзүүлэлтийг гаргавал дараах байдалтай байна.

	1-р	2-р	3-р	4-р	5-р	6-р	7-р	8-р	9-р	10-р	11-р	12-р
Дорнод					1				3	2		3
Сүхбаатар				1							1	
Хэнтий				1	2				2	1	2	4
Дорноговь				1					1		1	
Дундговь					1					1	3	1
Өмнөговь				1	2	1				1	4	1
Булган	3			2					2		2	
Архангай					1							
Өвөрхангай				1						1		
Хөвсгөл				1								
Сэлэнгэ				1	1					3	2	
Төв				2					1			1
Завхан				1					4	1		2
Увс				1				2	1	1	2	
Ховд												
Говь-Алтай				1	4	2	2	1	3	3	4	2
Баянхонгор					1							
Баян-Өлгий				1								
Говьсүмбэр				1		1				2	3	
Орхон				1					1			
Дархан-Уул										2	1	4

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу Комиссын цахим хуудас, болон олон нийтийн сүлжээ хуудаст үйл ажиллагааны талаар нийт 30 орчим гэрэл зураг, 10 орчим мэдээ мэдээллийг байршууллаа.

“Эрх зүйн хөтөч” нэвтрүүлэгт Комиссын ажилтнуудыг оролцуулах хуваарь, сэдэвчилсэн төлөвлөгөөг батлан ажиллав. 2015 оны 7 дугаар сарыг дуустал доорх хуваарийн дагуу нэвтрүүлэгт яриа өгч оролцлоо.

#	Хугацаа	Сэдэв	Хариуцах хүн
1	1 сарын 10	1. Хүний эрхийн ерөнхий ойлголт	Б.Болорсайхан
		2. Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ үзүүлж буй газруудад хийсэн хяналт шалгалтын талаар	Т.Ихтамир
		3. Ахмад настны эрхийн асуудлаарх Комиссоос гаргасан зөвлөмжийн талаар	Т.Ихтамир
2	1 сарын 21	4. Хүн бүр хүний эрхийн тэмцэгч	Ч.Алтангэрэл
		5. Хүний эрхийн боловсрол	
3	2 сарын 5	6. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хэрэгжилт /орчны хүртээмжтэй байдлын талаар хийсэн хяналт шалгалт, ХБИ-ийн оролцоо/	Б.Сэмжидмаа
		7. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх	ОТБЗ гишүүн
4	2 сарын 15	8. Гэр бүлийн хүчирхийлэл	Х.Мөнхзул
		9. Эмэгтэйчүүдийн эрх	
5	3 сарын 5	10. Хүний эрхийг хангах олон улсын механизм	Г.Агар-Эрдэнэ
		11. Ахмад настны эрх	
6	3 сарын 15	12. Эрүү шүүлтээс ангид байх эрх, Урьдчилан сэргийлэх үндэсний механизм бий болгох нь	Б.Батаа
		13. Комисст гомдол гаргах нь	
7	4 сарын 5	14. Хүний эрхийн зөрчлийг хэрхэн таних вэ?	Л.Дүгэрсүрэн
		15. Жендэрийн тэгш байдал ба хүний эрх	
8	4 сарын 15	16. Ажлын байрны бэлгийн дарамт	Х.Цэцгээ
		17. Хохирогчийн эрх	
9	5 сарын 5	18. Халдашгүй дархан байх эрх	Л.Дүгэрсүрэн
		19. Мэдэх эрх	
10	5 сарын 15	20. Хөдөлмөрлөх эрх	З.Бадмаараг
		21. Бизнес ба хүний эрх	
11	6 сарын 5	22. Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ	А.Дашдэлэг
		23. Эрүүл мэндээ хамгаалуулах эрх	
12	6 сарын 15	24. Эд мөнгөний тусламж авах эрх	Г.Золзаяа
		25. Шашин шүтэх, эс шүтэх эрх	
13	7-8 сард	26. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа	Ө.Ундрах

ГУРАВ. ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Комиссын тухай хуульд Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын бүрэн эрх, чиг үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулах ажлын хүрээнд Хууль зүйн дэд сайд Ц.Уугангэрэлд 2015 оны 5 дугаар сарын 19-ний өдөр албан бичгээр мэдээлэл хүргүүлэв. Хууль зүйн яамнаас байгуулагдсан ажлын хэсэг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хариуцан боловсруулах үед уг ажлын хэсэгт Комиссын төлөөлөл орж ажилласан бөгөөд хуулийн төсөлд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмын чиг үүргийг Комисст олгохоор тусгаж, Нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байсан болно. Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Нэмэлт протоколыг соёрхон баталсны дараа тусад нь хэлэлцэх нь зүйтэй гэж тухайн үед шийдвэрлэсэн бөгөөд одоогоор ямар нэгэн арга хэмжээ аваагүй байна.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хүний эрх зөрчигдөж буй шалтгаан нөхцөл, эрсдэлийг судлан сонгон авсан объектод хяналт шалгалтын ажил зохион байгуулах ажлын хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Хорих анги-9, Цагдан хорих байр-5, Баривчлах, захиргааны журмаар саатуулах байр-6, Зэвсэгт хүчний жанжин штабын харьяа 032 дугаар ангийн сахилгын хорих байранд-1 тус тус хяналт шалгалт зохион байгуулж хүний эрхийн зөрчлийг арилгуулахаар Комиссын гишүүний шаардлага, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Комиссын гишүүний зөвлөмжийг хүргүүлсэн байна.

2015 оны 6 дугаар сарын 26-ны өдөр “Эрүү шүүлт болон хохирогчийн эрхийн өнөөгийн төлөв байдал, цаашид анхаарах асуудал” сэдвээр дугуй ширээний уулзалт хэлэлцүүлэг хийв. Хэлэлцүүлэгт Хууль зүйн яам, Улсын дээд шүүх, Улсын Ерөнхий прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Тахарын Ерөнхий газар, Монголын хуульчдын холбоо, Хууль зүйн үндэсний хүрээлэн зэрэг 10 гаруй байгууллагын 60 орчим төлөөлөл оролцож, эрүү шүүлт болон гэмт хэргийн хохирогчдын эрхийг хамгаалах чиглэлээр явуулж буй үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудал, цаашид авах арга хэмжээний талаар санал солилцож, үндэсний урьдчилан сэргийлэх механизмын ач холбогдлын талаар Комисс мэдээлэл хийв.

ДӨРӨВ: ЗАХИРГАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

4.1 Гадаад хамтын ажиллагаа

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь Ази, Номхон Далайн бүс нутгийн Хүний эрхийн үндэсний байгууллагуудын Чуулганы (АНДЧ) ээлжит 20 дахь хурлыг Улаанбаатар хотноо 2015 оны 8 дугаар сард амжилттай зохион байгууллаа. Энэ удаагийн хуралд Ази, Номхон далайн бүс нутгийн 28 улсын Хүний эрхийн үндэсний байгууллага, иргэний нийгмийн байгууллага, Хүний эрхийн хамгаалагчдын асуудал эрхэлсэн НҮБ-ын Тусгай илтгэгч болон Хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах үндэсний байгууллагуудын Олон Улсын Зохицуулах хорооны төлөөлөгч зэрэг нийт 160 орчим зочид, төлөөлөгч оролцлоо.

Хоёр жил тутам уламжлал болгон зохион байгуулдаг АНДЧ-ны хурал нь Ази, Номхон далайн бүс нутаг дахь хүний эрхийн тулгамдсан асуудал, зөрчил, нөхцөл шалтгаан, тэдгээрийг шийдвэрлэж буй ХЭҮБ-уудын арга туршлага солилцох, хамтын ажиллагааг өрнүүлэх, бодлогын асуудлаар хамтын шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлдэг тул чухал ач холбогдолтой билээ. АНДЧ-ны Удирдах Зөвлөлийн хурлаар 2015-2017 онд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс АНДЧ-ыг даргалж, ажиллахаар болсон билээ. Мөн хүний эрхийн үндэсний байгууллагуудын Олон Улсын Зохицуулах Хорооны Бизнес ба хүний эрхийн Ажлын хэсгийн гишүүнээр Ази Номхон Далайн Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын Чуулганыг төлөөлөн Комиссын гишүүн П.Оюунчимэг сонгогдов. Энэ нь Ази, Номхон далайн бүсийн хэмжээнд хүний эрх, эрх чөлөөний талаар үйл ажиллагаа явуулдаг байгууллага, талуудтай үр нөлөөтэй хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой үйл явдал боллоо гэж үзэж байна.

Олон улсын зохицуулах хорооны 28 дугаар Ерөнхий хуралд 2015 оны 3 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд АНДЧ-ны хуралдаан, ОУЗХ-ны Товчооны хурал, ОУЗХ-ны 28 дугаар ээлжит Ерөнхий Хуралд Комиссын дарга, гадаад харилцааны референт оролцов.

Мексик Улсын Мерида хотод 2015 оны 10 дугаар сарын 5-10 өдөр болсон Олон Улсын Зохицуулах Хорооны 12 дугаар Олон Улсын Бага хуралд Комиссын дарга, гадаад харилцааны референт оролцов.

ОУЗХ-ны Товчооны хуралд Комиссын дарга Ази Номхон Далайн Чуулганы даргын хувьд сүүлийн нэг жилийн хугацааны үйл ажиллагааны талаар мэдээлэл хийв. Мөн Комиссын дарга Ж.Бямбадорж, АНДЧ-ны Нарийн бичгийн даргын газрын захирал К.Фицпатрик, дэд захирал П.Дарган нарын хамтаар АНДЧ-наас ОУЗХ-ны Магадлан итгэмжлэх дэд хорооны гишүүний сонгууль албан тушаалтай холбогдуулан Йордан болон Палестины хүний эрхийн үндэсний байгууллагуудын хооронд гарсан маргааны асуудлыг маргалдагч талуудыг оролцуулсан уулзалт зохион байгуулан хэлэлцэж зөвшилцөлд хүргэн, үр дүнг Товчооны хуралд танилцуулав.

Уулзалтын үеэр Филиппин, Өмнөд Солонгос зэрэг улсын ХЭУБ-ын удирдлагуудтай уулзалт хийх, санамж бичигт гарын үсэг зурах хугацаа товлох, туршлага солилцох аялал зохион байгуулах зэрэг ажлыг хэлэлцэн тохирсон байна. Дээр дурдсан нийт албан томилолт, гадаад арга хэмжээний талаар 10 гаруй илтгэх хуудас бэлтгэн удирдлагад танилцуулж, холбогдох хэлтэс, байгууллагуудад мэдээлэл хүргүүлэв.

НҮБ-ын ХЭДКГ, APF, ICC-тай тогтмол харилцаатай, байнгын мэдээлэл солилцон ажиллаж байна. Энэ хүрээнд НҮБ-ын ХЭДКГ болон APF-с ирүүлсэн төслийн санал болон хүний эрхийн асуудлаарх мэдээлэл, судалгаа, АНДЧ-ны гишүүн байгууллагын мэдээлэл шинэчлэх судалгааны асуумжийг бөглөн хариуг Чуулганы Ажлын албанд илгээв.

Филиппин Улсын Хүний эрхийн Комисстой хамтран уул уурхайн салбарт “Хүний эрхийн нөлөөллийн байдлын үнэлгээ хийх” туршлага судлах айлчлалыг зохион байгуулав. Уг айлчлалаар Филиппиний Комиссын төлөөлөлтэй уулзаж, нөлөөллийн үнэлгээ хийх туршлага, төрийн өмчит уул уурхайн компанийн олборлолт явуулж буй газарт очиж үйл ажиллагаатай нь танилцсан байна.

Данийн Хүний эрхийн Хүрээлэнтэй байгуулах санамж бичгийн төслийг боловсруулан орчуулж, Данийн Хүний эрхийн Хүрээлэнд Санамж бичигт гарын үсэг зуруулах англи, монгол хувийг илгээгээд байна. Мөн Комиссын гишүүн П.Оюунчимэг Тайваний Контрол Юаны Хүний эрхийг хамгаалах хороотой санамж бичиг зурах айлчлал хийв.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх, тулгамдаж буй асуудлаар судалгаа, хяналт шалгалтын болон нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулахад шаардагдах зардал, санхүүжилтийг олох зорилгоор олон улсын хандивлагч байгууллага, төслийн тэтгэлэгт хөтөлбөрт төслийн саналууд боловсруулж хүргүүлэх ажлыг зохион байгуулав. Үүнд:

- 2015 оны 1 дүгээр улиралд НҮБ-ын Траст Сангийн зарласан төслийн уралдаанд “Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг үйл ажиллагаа” төслийг явуулсан хариу аваагүй.
- 2015 оны 2 дугаар улиралд Европын Комиссын зарласан тэтгэлэгт хөтөлбөрт “Монгол Улс дахь хүүхдийн эрхийн төлөөх үйл ажиллагаа” төслийн саналыг Японы Хүүхдийг ивээх сангийн хамтаар тус тус боловсруулж хүргүүлсэн боловч шалгаруулалтын хоёр дахь шатнаас хасагдсан байна.
- 2015 оны 4 дүгээр улиралд Шинэ Зеландын Элчин сайдын яамны Монгол Улсад дэмжлэг үзүүлэх сангийн жижиг тэтгэлэг шалгаруулах уралдаанд “Эрүү шүүлтээс

урьдчилан сэргийлэх Үндэсний механизм"-ын үр нөлөөг нэмэгдүүлэх нь" төслийн саналыг хүргүүлээд байна.

ХЭҮК, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлсэн "Хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих үндэсний чадавхийг бэхжүүлэх төсөл"-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлж, 2015 оны эхний хоёрдугаар сард эцсийн тайлан боловсруулж, төслийн хаалтын үйл ажиллагааг зохион байгуулав. Төслийн дэмжлэгтэйгээр Хүний эрхийг хамгаалагчдын эрхийн хэрэгжилтийн талаарх судалгааг 2014 оны 12 дугаар сараас 2015 оны 2 дугаар сарыг дуустал сүүлийн 3 жилийн байдлыг хамруулан зохион байгуулахад санхүүжилтийн болон арга зүйн талаас дэмжлэг үзүүлж ажиллав. Улмаар төсөл хаагдсантай холбогдуулан тус төслийн санхүүжилтээр худалдан авсан тоног төхөөрөмжийг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн бүртгэлээс хасалт хийлгэн, Төрийн өмчийн хороонд мэдэгдэн ХЭҮК-ын бүртгэлд шилжүүлэх ажлыг зохион байгуулав.

Хүний эрхийн чиглэлээр олон улсын хурал зөвлөгөөн, сургалт, семинарт ажилтнуудыг хамруулах боломжийг судалж гишүүд, ажилтнуудыг гадаад сургалтад хамрагдах нөхцөлийг бүрдүүлж ажиллав. 2015 онд ХЭҮК-ын дарга, гишүүд, ажлын албаны ажилтнууд нийт 25 олон улсын арга хэмжээнд /уулзалт, хурал/ давхардсан тоогоор 30 хүн оролцсон байна. Үүнд:

ХЭҮК-ын дарга, гишүүд, ажилтнуудын 2015 оны гадаад томилолт

	Комиссын төлөөллийн нэр	Хурал, чуулганы нэр	Зохион байгуулагч	Хэзээ	Хаана
1.	Б.Сэмжидмаа референт	"Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд" сургалт		2. 23-наас 4. 3-ны өдөр	Энэтхэг
2.	Комиссын дарга Ж.Бямбадорж, референт Ө.Ундрах	ОУЗХ-ны 28 дахь удаагийн ерөнхий уулзалт	ОУЗХ болон ХЭДКГ	2015.03.11- 2015.03.13	ШХУ-ын Женев хот
3.	Комиссын дарга Ж.Бямбадорж, Ажлын албаны дарга А.Дашдэлэг, Хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, Ч.Алтангэрэл, референт Э.Туул	Филиппин Улсын Хүний эрхийн Комиссоос уул уурхайн салбарт хийж буй хүний эрхийн нөлөөллийн үнэлгээний ажилтай танилцах, харилцан туршлага солилцох айлчлал	Швейцарийн Хөгжлийн Агентлагийн санхүүжилт	2015.04.07- 2015.04.12	Филиппин Улсын Манила хот
4.	Комиссын гишүүн П.Оюунчимэг	Зэвсэгт хүчин дэх жендэрийн холбоотой гомдолд хариу арга хэмжээ авах	Зэвсэгт хүчний ардчилсан хяналтын Женевийн төв,	2015.04.28- 2015.04.30	ШХУ-ын Женев хот
5.	Комиссын ахлах референт Ц.Адъяахишиг, референт Ж.Оюунхүү	ХЭҮБ-уудын номын сан болон мэдээллийн төв хариуцсан ажилтнуудад зориулж зохион байгуулсан өмнөх сургалтын үр дүнг үнэлэх, цаашдын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох Бүсийн бага хурал	Раул Валленбергийн Институт, ХЭҮБ-уудын АНДЧ, Шведийн олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны агентлаг	2015.05.20- 2015.05.22	Тайланд Улсын Бангкок хот
6.	Комиссын гишүүн П.Оюунчимэг	БНХАУ-ын Тайваны Control Yuan-ы Хүний эрхийг хамгаалах хороотой санамж бичиг зурах	БНХАУ-ын Тайваны Control Yuan	2015.05.10- 2015.05.14	Тайван Улсын Тайпей хот

		айлчлал			
7.	Ажлын албаны дарга А.Дашдэлэг	Европын Хөгжлийн өдрүүд 2015 сэдэвт чуулга уулзалт	Европын Комисс	2015.06.02- 2015.06.05	Бельгийн Вант Улсын Брюссель хот
8.	Комиссын дарга Ж.Бямбадорж	“Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллагын бүс нутагт Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалахад Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын гүйцэтгэх үүрэг” сэдэвт семинар	Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллага	2015.06.01- 2015.06.03	Польш, Варшав хот
9.	Комиссын дарга Ж.Бямбадорж	“Энх тайвны хөгжил: Фашизм, милитаризмын эсрэг дайны ялалт ба хүний эрхийн хөгжил”	Хүний эрх судлал Хятадын Нийгмийн төв хариуцах болно	2015.09.16- 2015.09.17	БНХАУ Бээжин хот
10.	Комиссын гишүүн П.Оюунчимэг	Зэвсэгт хүчний омбудс байгууллагуудын 7 дахь удаагийн олон улсын бага хурал	DCAF болон Чехын Батлан хамгаалах ям хамтран DCAF	2015.10.25- 10.27	БНЧУ-ын Праг хот
11.	Комиссын дарга Ж.Бямбадорж, ЗХАХ референт Ө.Ундрах	Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үндэсний байгууллагуудын Олон Улсын Зохицуулах Хороо(ОУЗХ)-ны 12 дугаар Олон Улсын Бага хурал	ОУЗХ, Мексикийн Хүний эрхийн Комисс	2015.10.06- 2015.10.10	Мексикийн Нэгдсэн Улсын Мерида хот
12.	Комиссын дарга Ж.Бямбадорж, Хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ,	АСЕМ-ын уулзалт болон Ахмад настны эрхийн талаарх хурал	ОУЗХ, БНСУ- ын ХЭҮК	2015.10.26- 2015.10.28	БНСУ, Сөүл хот
13.	Ажлын албаны дарга А.Дашдэлэг	АНДЧ-ны ХЭҮБ-уудын Ажлын албаны дарга нарын уулзалт	АНДЧ	2015.11.02- 2015.11.08	Малайз
14.	Хэлтсийн дарга Ч.Алтангэрэл	“Хүүхдийн эрхийн хараат бус хяналт үнэлгээ хийх нь олон улсын уулзалт, семинар”	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан	2015.12.05- 2015.10.10	БНАСВУ Ханой хот

2015 онд ХЭҮК-ын ажилтнуудын гадаад улс оронд хамрагдсан сургалтын жагсаалт

№	Комиссын төлөөллийн нэр	Хурал, чуулганы нэр	Зохион байгуулагч	Хэзээ	Хаана
1	Ахлах мэргэжилтэн Г.Золзаяа	ЛГБТ хүмүүсийн эрхийн асуудлаарх семинар	АНДЧ болон НҮБХХ	2015.02.24- 02.25	Тайланд Улсын Бангкок хот
2	Хэлтсийн дарга Б.Батаа	Эрүү шүүлтийг мөрдөн шалгаж, баримтжуулах талаарх бүсийн холимог сургалт	Ази Номхон Далайн бүс нутгийн ХЭҮБ- уудын Чуулган	Цахим сургалт 2015.03.16- 2015.04.10; Танхимын сургалт 2015.04.20- 2015.04.24	Филиппин Улсын Манила хот
3	Ажлын албаны дарга А.Дашдэлэг	ХЭҮБ-уудад зориулсан Бизнес ба хүний эрхийн тухайн танилцуулга	Ази Номхон Далайн бүс нутгийн ХЭҮБ-	Цахим сургалт 2015.03.16-	Тайланд улсын Бангкок хот

			уудын Чуулган болон Данийн Хүний эрхийн Хүрээлэн	2015.04.10; Танхимын сургалт 2015.05.04- 2015.05.08	
5	Референт Т.Ариунаа	“Хүний эрхийн хамгаалагчдын 2015 оны Түншлэлийн хөтөлбөр”	Солонгос Улсын ХЭҮК	2015.05.18- 2015.05.22	БНСУ-ын Сөүл хот
6	З.Өнөржаргал	“Сонгуулийн урт хугацааны ажиглагчийн сургалт”	Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллагын Ардчилсан институт, хүний эрхийн газар	2015.06.29- 2015.07.03	Серб Улсын Белград хот
7	Ч.Алтангэрэл	“Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын 2015 оны Академи” сургалт	Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллагын Ардчилсан институт	2015.06.29- 2015.07.03	Польш, Варшав хот
8	Б.Болорсайхан	“Азийн клиник эрх зүйн боловсролын зуны сургалт” сэдэвт семинар	Брижес Хил Дамнасан Олон Нийтийн Эрх зүйн Боловсролын Санаачилга байгууллага	2015.06.05- 2015.06.14	Тайландын Вант Улсын Чиангмай хот
9	Г.Золзаяа	“36 дахь Олон улсын хүний эрхийн сургалтын хөтөлбөр” сургалт	EQUITAS -Олон улсын хүний эрхийн боловсролын төв	2015.06.07- 2015.06.26	Канад, Монреаль хот

4.2 Дотоод хамтын ажиллагаа

Орон тооны бус зөвлөлийн ээлжит хурлыг улирал тутам зохион байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө, 2015-2020 оны стратеги төлөвлөгөөг танилцуулж, гишүүдийн санал, зөвлөмжийг Комиссын стратеги төлөвлөгөөнд тусгасан. Хүний эрхийн тулгамдаж байгаа болон цаг үеийн зарим асуудлаар гишүүд санал солилцов.

Мөн хурлаар Комиссын төсөв санхүүжилттэй холбоотой мэдээлэл бэлтгэн гишүүдэд танилцуулсан.

“Хүний эрхийн тухай ярилцъя” Өглөөний уулзалтыг Хүний эрхийн Үндэсний Комисс, Нээлттэй Нийгэм Форум ТББ-тай хамтран уламжлал болгон зохион байгуулж ирлээ. Энэ уулзалтад ХЭҮК-ын Ажлын албаны ажилтнууд болон иргэний нийгмийн байгууллагын төлөөллүүдийг оролцуулан сар тутамд зохион байгуулж хэвшээд байна. 2015 онд зохион байгуулсан Өглөөний уулзалтын сэдэв, илтгэгч, огноог дараах хүснэгтээс танилцах боломжтой. Үүнд:

№	Сэдэв	Мэдээлэл хийсэн ТББ	Огноо
1.	Тогтвортой хөгжлийн зорилго	Транспэрэнси Интернэшнл Монгол	1 сарын 22, 2015

2.	Шүгэлдэгч	Глоб Интернэшнл төв	2 сарын 12, 2015
3.	Захиргааны ерөнхий хууль	Захиргааны ерөнхий хуулийн ажлын хэсгийн гишүүд	3 сарын 19, 2015
4.	Химийн бодис бидний амьдралд	Байгаль орчин, эрүүл мэнд төв	4 сарын 23, 2015
5.	Хүнсний аюулгүй байдлын баталгаажилт, мэдэх эрх	Хүнс эвсэл	6 сарын 18, 2015
6.	1930-1940 оны улс төрийн хэлмэгдлийн үр дагавар	Цаазлагдсан улс төрийн хэлмэгдэгчийн хүүхэд	9 сарын 17, 2015
7.	Цэнхэр сав буюу аюул дагуулсан хэрэглээ	Заша өвс төв	10 сарын 22, 2015
8.	Ураны уурхай-Хүний эрх	Их Бага Баяншарга	11 сарын 19, 2015

Жендэрийн тэгш байдлыг хангах дунд хугацааны стратегийн үндэсний үнэлгээ хийхэд хамтран ажиллах уулзалтын хүрээнд 2015 оны 10 дугаар сарын 02-ны өдөр Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Амарсайхан, Жендэрийн үндэсний хорооны Ажлын албаны дарга Рэнцэнханд, зөвлөх Т.Амгалан нартай уулзалт зохион байгууллаа.

ТАВ. КОМИССЫН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

5.1 Комиссыг чадавхижуулах, бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа

Дотоод сургалтын хэрэгцээ шаардлагын талаар ажилтнуудаас санал авсны дагуу төлөвлөгөө гарган нийт 11 удаа сургалт зохион байгууллаа. Үүнээс 8 сургалтыг дотоод нөөц бололцоонд тулгуурлан, 3 сургалтад мэргэжлийн байгуулагуудаас багш урьж хийсэн байна.

Комисст дадлагажигчаар ажиллаж байсан Австрали улсын сайн дурын ажилтан Крисс.Р болон Комиссын ажилтнууд дараах сургалт хийсэн байна. Үүнд: 2015.01.23-нд “Комиссын илтгэл боловсруулах туршлага, илтгэлийн загварчлал”, 2015.02.13-нд “Өмчлөх эрх”, 2015.03.06-нд “Хүний эрхийн ойлголт”, “хүний эрхэд суурилсан хандлага”, 2015.04.17-нд “Насаар ялгаварлан гадуурхалт, ахмад настны эрх”, “Захиргааны актад ДШ хийх аргачлал, 2015.06.20 ЭШЭНП ба УСМ хийх нь”, 2015.12.23 “Төрийн албан хаагчийн ёс зүй”. Мөн АТГ-ын УССГХэлтсийн Ахлах ажилтан Д.Цэнд-Аюушийг урьж “Авлига ба хүний эрх” сэдвээр 2015.10.09, Бичиг Соёл Монгол Уран бичлэгийн холбооны Удирдах Зөвлөлийн гишүүн Д.Ганбаатарыг урьж “Монгол бичиг” насанд хүрэгчдэд зориулсан сургалтыг 2015.11.25-ны өдөр тус тус зохион байгуулж Ажлын албаны ажилтнууд оролцлоо. Дотоод сургалтын мэдээллээ цахим хуудсын орон нутгийн ахлах мэргэжилтнүүд нэвтрэн ордог буланд байршуулж ажиллаж байгаа болно.

Швейцарийн хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төсөл “Орон нутгийн хөгжилд бичил уурхайгаас оруулах эдийн засгийн хувь нэмэр” сэдэвт зөвлөгөөнд Комиссын орон нутаг дахь ахлах мэргэжилтнүүд оролцож, мэдээлэл солилцлоо. Уг зөвлөгөөн нь бичил уурхайн эдийн засгийн ач холбогдлын талаар оролцогч талуудыг зөв мэдээллээр хангах, эдийн засгийн хувь нэмрийг сурталчлан

таниулах зорилготой бөгөөд Төвийн бүсийн зөвлөгөөнийг 2015 оны 10 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд Дархан-Уул аймагт, баруун бүсийнхийг 2015 оны 10 дугаар сарын 21-22-нд Баянхонгор аймагт, зүүн болон говийн бүсийн зөвлөгөөнийг 2015 оны 10 дугаар сарын 28-29-нд тус тус хийсэн бөгөөд Комиссын нийт 16 ахлах мэргэжилтнүүд оролцож, мэдээлэл танилцууллаа.

Комиссын мэдээлэл лавлагааны төв нь комиссын дотоод дүрэм журамд нийцүүлэн ажиллаж байна. 2015 оны байдлаар Комиссын номын санд Монгол хэл дээр 2150 нэр төрлийн 5236, гадаад хэл дээр 1324 нэр төрлийн 2413, нийт 7649 ширхэг ном товхимол бүртгэлтэй байна. Энэ оны байдлаар мэдээлэл лавлагааны төвөөр үйлчлүүлсэн комиссын ажилчид давхардсан тоогоор 60, Их дээд сургуулийн оюутнууд 65 удаа үйлчлүүлж 301 ном товхимол уншилтад гаргасан байна. Комиссын номын санд байгаа нийт номыг программд бүртгэхтэй холбоотойгоор хуучин ашиглаж байсан LIB4U програмыг “Волвес ХХК”-аар лицензийг 2015 оны 6-р сарын 25-ны өдөр шилжүүлэн суулгаж, LIB4U програмд 2015 оны 9 дүгээр сарын 4-ний өдрөөс эхлэн ном товхимлуудыг бүртгэн ажиллаж байна. Одоогийн байдлаар нийт 1069 ном бүртгээд байна.

5.2. Комиссын хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн үйл ажиллагаа

Комиссын хурлыг 2015 онд 16 удаа хийж нийт 49 асуудал авч хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Хурлын бэлтгэл ажлыг хангаж, тэмдэглэлийг хөтөлж баримтжуулсан. Комиссын даргын 30, Ажлын албаны даргын 74 нийт 103 тушаалын төсөл боловсруулж, танилцуулан, албажуулсан байна.

Үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө, тайлан, мөн сар бүрийн төлөвлөгөө тайлан боловсруулах ажлын хүрээнд аймгийн ахлах мэргэжилтнүүдээс нийт 180 гаруй тайлан хүлээн авч, уншиж, нэгтгэн цаг ашиглалтын байдлыг гаргаж ажиллав.

ҮАБЗ-д явуулах тайлан мэдээллийг боловсруулж 2015.02.02-нд, хагас жилийн мэдээллийг 2015.07.03-нд тус тус хүргүүлэв.

2015 оны сар бүрийн төлөвлөгөөний хэрэгжилтэд дотоод үнэлгээ хийж ажилласны дагуу жилийн эцсийн төлөвлөгөөний биелэлтийг гаргаж байна.

Төсвийн гүйцэтгэлийн болон нийгмийн даатгалын тайланг сар бүр гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэхээс гадна гүйцэтгэлийн тайланг хүргүүлсэн. Комиссын 2016 оны Төсвийн төслийг боловсруулан Сангийн яаманд хуулийн хугацаанд нь хүргүүлэв. Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд байгууллагын цахим хуудаст тавигдах мэдээллийг тухай бүрт нь боловсруулж мэдээллийн самбарт байгаа санхүүгийн булангийн мэдээллийг сар бүр шинэчилж нийтэд ил тод, нээлттэй мэдээлж ажиллалаа.

Хөрөнгө оруулалтын санхүүжилт 2015 оны төсөвт батлагдаагүй тул худалдан авалт хийгдээгүй болно.

2014 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын комисс тооллого хийж, элэгдлийн хугацаа дууссан эд хөрөнгийг актлуулах хүсэлтийг хавсралт баримтын хамт Төрийн өмчийн хороонд хүргүүлсэн байна.

Комиссын санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагааг хөтөлж, мэдээллийн технологийн төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж, дотоод сүлжээ, компьютер, хэвлэх төхөөрөмжид гарсан гэмтэл доголдлыг засч ажилласан бөгөөд Антивирусны

программын хугацаа нь дууссан 30 компьютерт шинээр антивирусны программ суулгасан байна.

2015 оны 12-р сарын 22-ны өдрийн байдлаар Комисст нийт 647 албан бичиг, иргэдийн 631 гомдлыг хүлээн авч, зохих журмын дагуу цахим болон журналаар бүртгэн танилцуулж шийдвэрлэлтийн үр дүнг эргэн мэдээлэх ажилд туслалцаа үзүүлэн ажиллаж байна. Мөн Комиссоос 907 албан бичиг, 40 зөвлөмж, 37 шаардлага, 1 төлөөлөн нэхэмжлэл боловсруулан холбогдох байгууллага, иргэдэд зохих журмын дагуу хүргүүлэх, Удирдлагын цахим программын файлын санд байршуулах зэрэг ажлыг гүйцэтгэлээ.

2015 оны 12-р сарын байдлаар архивын баримтыг-270 удаа Комиссын ажилтнуудад түр ашиглуулж, хэвлэмэл хуудас -3317 ширхэгийг дугаарлан, хуулбар үнэн болох тухай тэмдэг 61 удаа дарж баталгаажуулсан байна.

2014 онд батлагдсан хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу ажилтнуудаас архивын баримт хүлээн авч, нийт байнга хадгалах-40, түр хадгалах-31 хадгаламжийн нэгж бүрдүүлж, үдэж хавтаслан, бүртгэх ажлыг хийлээ.

Кино, дуу, дүрс, гэрэл зураг зэрэг тусгай төрлийн баримтыг эмхлэн цэгцэлж, ангилан төрөлжүүлж, хадгаламжийн нэгж бүрдүүлсэн байна. Үүнд: Гэрэл зургийн цомог 7 ш /2001-2007он/, кино, гэрэл зураг, аудио, видео хуурцаг 97 хадгаламжийн нэгж /2001-2007он/, DVD, CD- 85 ш /2005-2014он/ бүртгэл хөтөлсөн байна. Байгууллагын түүхчилсэн лавлах боловсруулах, архивын гэрчилгээ хөтлөх, 2007-2014 оны данс бүртгэлийг нэгтгэж, батлуулах зэрэг ажлыг гүйцэтгэлээ.

2015 оны 9 дүгээр сарын 29-өөс 10 дугаар сарын 05-ны хооронд архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт дараах 4 төрлөөр хамрагдаж, үнэлгээ авсан байна. Үүнд: Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлж буй байдалд 86,42% буюу В үнэлгээ, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтанд 92,1% буюу А үнэлгээ, байгууллагын архивын ажилд - 95% буюу А үнэлгээ, байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд -91.85% буюу А үнэлгээ тус тус авч, нийт 91.34 буюу А үнэлгээгээр дүгнэгдсэн болно.

Мөн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Үндэсний аудитын газар хүргүүлж, аудит хийлгэн “Зөрчилгүй” дүгнэлт авсан болно. Комиссын даргын баталсан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах дотоод журмын дагуу хариуцсан мэдээлийг шилэн дансны цахим хуудаст болон ханын самбарт хуулийн хугацаанд нь байрлуулж хэвшээд байна.

Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн аргачлалын дагуу Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьж тайланг хугацаанд нь АТГ-т хүргүүлэв. 2015 оны тайланд шинжээчдийн багийн хийсэн үнэлгээгээр Комисс 77 оноо авч өмнөх оны 62.1 оноог 15 оноогоор ахиулсан байна. Мөн 2014 оны ХАСМ болон Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны нэрсийн жагсаалт, мэдүүлэг гаргагч нийт 20 албан тушаалтнаас хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулж, цаасан болон цахим хэлбэрээр хүлээн авч, www.meduuleg.iaac.mn программ, журналд бүртгэн бүрэн хамрууллаа. ХАСХОМ-1, ХАСХОМ-2 маягтын дагуу мэдүүлгийн тайланг 2015.02.25-ны өдрийн 4/160 дугаар албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлэв. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хүлээн авсан тухай бүртгэл хөтлөн ажиллаж байна.

Комиссын нийт 47 албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөн, цалин хөлс, үр дүнгийн үнэлгээ зэрэг мэдээллийг шинэчлэн Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайланг ТАЗ-д 2015 оны 1 дүгээр сард цахим хэлбэрээр хүлээлгэн өгсөн. Байгууллагын сул орон тооны талаар олон нийтэд мэдээлэх ажлын хүрээнд Дорнод, Архангай аймагт ахлах мэргэжилтний, төвд референтийн сул орон тоог нөхөх захиалгыг боловсруулж ТАЗ-д хүргүүлж, Төрийн албаны зөвлөл, ХЭҮК-ын цахим хуудаст байршуулан ажилласан болно.

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН
АЖЛЫН АЛБА